УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ БА ЦАХИМ ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/210

Захиалагч: УИХ-ын гишүүн Л.Мөнхбаясгалан

Хянасан: ПСХХ-ийн захирал Д.Бумдарь (Ph.D.)

Судалгаа удирдсан: ПСХХ-ийн хэлтсийн дарга Ц.Норовдондог (Ph.D.)

Судлаачид: Д.Жигваагүнсэл, Б.Оюунчимэг, Л.Мишээлт

Улаанбаатар хот, 2024 он

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ. ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

1.1.Олон улсын туршлага

1.2.Монгол Улсын зохицуулалт

ХОЁР. ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ БА ЦАХИМ ЖАГСААЛ, ЦУГЛААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

2.1. Шведийн Хаант Улс

2.2. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

2.3. Бүгд Найрамдах Солонгос Улс

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөө ба цахим жагсаал, цуглааны эрх зүйн зохицуулалтын талаарх гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Судалгаанд гадаадын зарим орны жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөө ба цахим жагсаал, цуглаан зохион байгуулах эрх зүйн зохицуулалтын асуудлыг гадаадын зарим орны туршлагад тулгуурлан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Энэ судалгаанд жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөний талаарх олон улсын нийтлэг зохицуулалт, зарим хөгжингүй орон болон скандинавын орны жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөний асуудлыг зохицуулсан эрх зүйн актууд, цахим жагсаал, цуглаан болон биечлэн хийх жагсаал, цуглааны үеэр хэв журмыг хэрхэн сахиулж, иргэд, жагсагчдын аюулгүй байдлыг хангадаг талаарх зохицуулалт, практик туршлагыг судалсан болно.

Судалгаанд тухайн орнуудын холбогдох хууль эрх зүйн актууд, олон улсын баримт бичгүүд, ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ)-ын “Жагсаал, цуглааны үе шатыг хамгаалахад баримтлах хүний эрхийн гарын авлага”[1], ХЗҮХ-ийн “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн төсөлд зориулсан харьцуулсан судалгаа” зэрэг холбогдох эх сурвалжуудыг ашиглав.

Судалгааны бүтэц: Судалгаа нь хураангуй болон үндсэн 2 хэсэгтэй. *Нэгдүгээр хэсэгт*, Жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөний талаарх онолын ойлголт, олон улсын баримт бичгүүд дэх зохицуулалт, Монгол Улсын жагсаал, цуглаан зохион байгуулах эрх зүйн зохицуулалтын талаар, *Хоёрдугаар хэсэгт*, Хөгжингүй болон скандинавын орнуудын төлөөлөл болох Швед, ХБНГУ, БНСУ зэрэг орнуудын жагсаал, цуглаан болон цахим жагсаал, цуглаан хийх эрхийг хуулиар хэрхэн зохицуулж, баталгаажуулсан туршлага, тэдгээрийн хориглолт, хязгаарлалт, хамгаалалтын талаарх эрх зүйн орчны зохицуулалтыг тусгасан болно.

Түлхүүр үг: *Жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх, цахим жагсаал цуглаан, жагсаал, цуглааныг хориглох; жагсаал, цуглааны үеийн хэв журмын зохицуулалт; хязгаарлалт тавих.*

Key words: *Right to protest and assembly, freedom, right to express opinion, electronic demonstration, organization of demonstration and assembly, prohibition of demonstration and assembly, protection and restriction of stage of demonstration and assembly.*

---

[1] protection and restriction of stage of demonstration and assembly - (“жагсаал, цуглааны үеийн [хууль, эрх зүйн] хамгаалалт ба хязгаарлалт”-гэх маягтай буулгах зүйлийг “жагсаал цуглааны үе шатыг хамгаалах” гэж буруу орчуулснаас үүдэлтэй буруу ойлгогдохоор үг илэрхийлэл байгааг анхаарах! Ард иргэд, төр нийгмийн байгууллын аюулгүй байдлыг хангаж, нийтийн хэв журмыг сахиулах арга замаар иргэдийнхээ аюулгүй байдлыг хамгаална. Үүнд жагсаж байгаа болон жагсаалд оролцоогүй иргэдийн аюулгүй байдал хамаарна. Тэгэхээр “жагсаал цуглаан”-ыг биш харин иргэдийн аюулгүй байдал, иргэний эрх, эрх чөлөөг хамгаалдаг).

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

НҮБ-ын “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 20 дугаар зүйлд “хүн бүр чөлөөтэй тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй” хэмээн заасан байх бөгөөд 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлд “Тайван замаар хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө” гэжээ. Тиймээс энэхүү эрх, эрх чөлөөг бүс нутгийн хүний эрхийн гэрээ, улс орнуудын Үндсэн хуульд тодорхой зааж баталгаажуулсан байдаг.

Эдгээр хүний эрхийн үндсэн гэрээнүүдэд “аливаа ардчилсан нийгэмд энэ эрхийг хэрэгжүүлэхэд үндэсний аюулгүй байдал, нийтийн амгалан тайван байдал, төр нийгмийн байгуулал, нийтийн эрүүл мэнд, ёс суртахуун, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах тухай хуулийн заалтууд, мөн нийтийн эрх ашгийг хамгаалах ашиг сонирхол зэрэг зайлшгүй шаардлагуудтай нийцүүлэн хуулиар тогтоосноос бусад ямарваа хязгаарлалт тавьж болохгүй” хэмээн заасан байна.

Харин улс орнууд энэхүү эрхийг хамгаалан баталгаажуулахдаа үндэсний аюулгүй байдал, төр нийгмийн байгуулал, хүн амын эрүүл мэнд, соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангаж, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс зарим хязгаарлалтыг хийх зэрэг зайлшгүй шаардлагуудтай уялдуулан Үндсэн хууль болон бусад тусгай хуулиар зохицуулж байна.

Сонгон судалсан улс орнуудын хувьд, биечлэн зохион байгуулах жагсаал цуглааны талаар жагсаал, цуглааны тухай хуулиар зохицуулж байгаа бол цахимаар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх, эрх чөлөөг цахим харилцаа, холбооны тухай холбогдох хууль, хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, хувь хүний нууцын тухай хууль тогтоомжоор тус тус зохицуулж байна.

Судалгаанд авагдсан орнуудын жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөний талаарх эрх зүйн зохицуулалт:

Дэлхийн хүчирхэг гүрнүүдийн хоорондын хүчний төлөөх өрсөлдөөн эрчимжиж, олон улсын тогтсон дэг журамд өөрчлөлт орох хандлага улам бүр нэмэгдсээр байгаа өнөө үед улс орон бүр өөрийн гадаад, дотоод аюулгүй байдлыг хангах, хадгалах шаардлагатай болж байна.

Олон улсын хүний эрхийн зарчмуудад төр, түүний төлөөлөгч нь хүний бүх эрхийг хүндэтгэж, хамгаалах үүрэг, хариуцлага хүлээдэг.

Энэ ч үүднээс олон улсад “өнгөт хувьсгал” гэж нэрлэгддэг, гаднаас удирдлага, зохион байгуулалттайгаар аливаа нэг улсын дотоодод эмх замбараагүй байдал үүсгэх, төр нийгмийн аюулгүй байдлыг алдагдуулах, өөрчлөх зорилго бүхий үйл явц нь олон нийтийг хамарсан жагсаал, цуглааныг ашиглан хэрэгждэг гэдгийг судлаачид сануулсаар байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын холбогдох хуулийн зохицуулалтаас үзэхэд “иргэд сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх хууль ёсны эрхтэй. Гэхдээ энэ эрхээ хязгааргүй биш, харин “хууль, журам, ёс суртахууны хүрээнд зохицуулалттайгаар эдэлнэ” гэсэн үндэслэл, зарчмыг баримталж байна. Тухайлбал, ХБНГУ, БНСУ-ын хуулийн зохицуулалтаас харахад, жагсаал, цуглаан зохион байгуулагчид, зохицуулагчид, оролцогчдоос эрх, үүргийн талаарх мэдлэг, ойлголт сайтай байхыг

шаардаж, улмаар хэв журам болон аюулгүй байдлыг хангахад жагсаал цуглаанд оролцогчид, ялангуяа зохион байгуулагчид голлох үүрэгтэй байхаар зохицуулжээ.

Швед улсад **Үндсэн хуулиар** үг хэлэх эрх, хэвлэлийн эрх чөлөө болон тайван жагсаал цуглаан хийх эрхийг хамгаалдаг. Энэхүү эрхийг хязгааргүй гэж үздэг боловч нийгмийн аюулгүй байдал, нийтийн дэг журамтай зөрчилдөхгүй байх нөхцөлтэй. Харин **Олон нийтийн цуглааны тухай хууль** нь олон нийтийн жагсаал, цуглааныг зохион байгуулах нөхцөл, журам, хязгаарлалтыг тодорхойлсон. **Олон нийтийн тайван байдал болон дэг журмыг хамгаалах тухай хуулиар** олон нийтийн газар зохион байгуулагдах үйл ажиллагаа нь нийтийн дэг журам, аюулгүй байдлыг зөрчөөгүй байхыг шаарддаг. Хэрэв жагсаал, цуглаан нь нийгмийн аюулгүй байдалд заналхийлж байвал цагдаа болон орон нутгийн захиргаа түүнийг хориглож, тараах арга хэмжээ авах эрхтэй.

Мөн сонгон судалсан орнуудын ихэнх нь “аяндаа бөгөөд яаралтайгаар жагсаал, цуглаан хийх боломж нөхцөлийг огт хязгаарлаагүй ч жагсаал, цуглаан аль болох зохион байгуулах эзэнтэй байхыг илүүд үзэж байна. Тухайлбал, (ХБНГУ) аль нэг улс төрийн нам жагсаал, цуглаан зохион байгуулахад тухайн намын даргыг гол зохион байгуулагчаар тооцохоор заасан.

Энэ мэтчилэн жагсаал, цуглааны үеэр иргэдийн аюулгүй байдал, жагсагчдын эрхийг хамгаалахад зохион байгуулагч, зохицуулагч, оролцогчдын зүгээс цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж, нийгмийн амар тайван байдал, жагсаал, цуглааны аюулгүй байдлыг хангадаг байна.

Жагсаал, цуглаан зохион байгуулах эрхийн хувьд, сонгон судалсан улс орнуудад жагсаал, цуглааныг хүн бүр (ХБНГУ- субъектийн хязгаарлалтгүй), хувь хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй холбоод зохион байгуулж болох бөгөөд тийнхүү зохион байгуулагч нь тухайн улсын иргэн, удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй, эсхүл байнгын оршин суугч гадаадын иргэн байж болдог байна.

Тэгвэл зарим улсад Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн нам, намын хэсэг буюу түүнийг орлон гүйцэтгэгч байгууллагын зорилгыг сурталчлах үүднээс жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглосон байна. Энэ нь улс төрийн намын нийгмийн хүрээн дэх хариуцлага, сахилга батыг чухалчлах зорилготой зохицуулалт юм.

Жагсаал, цуглаан зохион байгуулах байршил, хугацааны хувьд: үзэгдэх орчин хязгаарлагдсан, аюулгүй байдал алдагдах, эмх замбараагүй байдал үүсэх нөхцөл бүрдэхээс сэргийлж шөнө орой хийхийг ихэнх оронд зөвшөөрдөггүй байна. Тухайбал, БНСУ-д жагсаал, цуглаан зохион байгуулах талаар урьдчилан мэдээлсэн, тухайн арга хэмжээний мөн чанар нь тухайн цагуудад зайлшгүй зохион байгуулахаас өөр аргагүй тохиолдол биш л бол нар мандахаас өмнө, эсхүл нар жаргасны дараа гадаа [гудамж талбайд] жагсаал, цуглаан хийж болохгүй хэмээн хуульчилсан.

Байршлын хувьд зөвшөөрөгдсөн газруудаас бусад газарт жагсаал, цуглаан хийхийг хориглохоос гадна олон нийтийн зорчих хэсэг, улсын төр захиргааны төв байгууллагууд, сургууль боловсролын газрууд, эмнэлэг, орон сууцны хороолол, түүх дурсгалын газруудад мөн хориглодог ба энэхүү зохицуулалт нийтлэг ажиглагдаж байна. (Хүснэгт 1)

Судалгаанд авагдсан орнуудын цахим жагсаал, цуглааны талаарх зохицуулалт:

Цахим жагсаал, цуглаан хийх эрх нь ардчилсан нийгмийн нэг чухал хэлбэр бөгөөд үүнийг зохицуулах эрх зүйн орчин нь тухайн орны хууль тогтоомж, олон улсын гэрээ, хүний эрхийн зарчимд үндэслэдэг. Хуулийн зохицуулалт нь цахим орчны аюулгүй байдлыг хангах, үг хэлэх эрхийг хамгаалахад чиглэхийн зэрэгцээ бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэхийг зэрэгцүүлэн шаарддаг. Тухайлбал, Шведийн Үндсэн хуулиар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулсан бөгөөд энэ эрх нь зөвхөн физик орчинд бус цахим орчинд ч мөн адил үйлчилдэг. Иймээс цахим жагсаал эсвэл олон нийтийн хэлэлцүүлэг нь Үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд хамгаалагдана. Цахим жагсаал, хэлэлцүүлэгт оролцогчид хууль бус агуулга, үзэл бодол илэрхийлэхгүй байх гэх мэт үүргийг холбогдох хууль тогтоомжоор хүлээдэг.

Олон оронд жагсаал, цуглаан хийхэд тусгай зөвшөөрөл авах шаардлагатай ба цахим жагсаалд ч мөн ижил зохицуулалт үйлчилдэг.

Түүнчлэн цахим жагсаалд оролцогчдын хувийн мэдээлэл хуулиар хамгаалагдах ёстой бөгөөд “Европын Холбооны мэдээлэл хамгаалах ерөнхий журам (GDPR)”-аар хувийн мэдээллийг цахим орчинд зохистой ашиглах, хамгаалах шаардлага тавьдаг байна.

Цахим жагсаал, цуглаан нь иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ардчилсан үйл явцад оролцох боломж нөхцөлийг бүрдүүлдэг, орон зай, цаг хугацааны хязгаарлалтаас үл хамааран богино хугацаанд өргөн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх, олон хүнийг татан оролцуулж санал авч, шийдвэр гаргахад нөлөөлөх, бодит жагсаал цуглааны зохион байгуулалттай харьцуулахад цаг хугацаа, зардлыг хэмнэх зэрэг давуу талтай.

Харин цахим орчин дахь олон нийтийн аюулгүй байдал, хувийн нууцад халдах, сошиал медиагийн хэт туйлширсан хэлэлцүүлэг үүсгэж, нийгэмд хуваагдмал байдал үүсгэх магадлалтай зэрэг сул талтай байдаг байна.

Жагсаал, цуглааныг хориглох, хязгаарлах эрх зүйн зохицуулалт:

Жагсаал цуглаанд хориг тавих гол үндэслэл нь аюулгүй байдал, нийтийн амгалан тайван байдал, төр нийгмийн байгуулал, нийтийн эрүүл мэнд, соёл иргэншил, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг зөрчих зэрэг байна. Харин жагсаал, цуглаанд хязгаарлалт тавих тухайд хугацааны, байршлын, оролцогчдын, бусад үйл ажиллагаатай зөрчилдсөний гэх зэрэг хэлбэртэй байна.

Хязгаарлалтыг жагсаал, цуглаан болохоос өмнө, жагсаал, цуглааны үеэр, эсвэл аль алинд нь тавьж болдог байна. Тухайлбал, зарим улсад жагсаал, цуглаан болохоос өмнө цагдаагийн байгууллага хязгаарлалт тогтоох үүрэг хүлээдэг бол, зарим улсад энэ эрх мэдэл нь орон нутгийн засаг захиргаа, шүүх гэх мэт тусгай эрх мэдэлтэй байгууллагад олгогдсон байдаг байна. (Хүснэгт 1)

Аливаа жагсаал, цуглаан нь тухайн төлөвлөсөн цагтаа зохион байгуулагдсан тохиолдолд иргэд үзэл бодлоо тухайн мөчид цаг алдалгүй илэрхийлэх ач холбогдолтой байдаг тул жагсаал, цуглааныг хориглосон шийдвэрийн талаарх гомдлыг шүүхээс богино хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байдаг.

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын хууль эрх зүйн орчин болон жагсаал, цуглааны хориглолт, хязгаарлалтын талаарх зохицуулалт

Хууль эрх зүйн орчны хүрээ	**<u>Швед:</u>** - Үндсэн хууль - Олон нийтийн цуглааны тухай хууль - Олон нийтийн тайван байдал болон дэг журмыг хамгаалах тухай хууль **<u>Герман:</u>** - Үндсэн хууль - Жагсаал цуглааны тухай хууль **<u>БНСУ</u>** - Үндсэн хууль - Жагсаал цуглааны тухай хууль
Жагсаал, цуглааныг хориглох нийтлэг үндэслэл	**<u>Швед:</u>** Зорилго нь арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг баримжаа гэх мэт үндсэн дээр үзэн ядах, ялгаварлах үйл ажиллагаа явуулахад чиглэсэн аливаа жагсаалыг хориглох эрхтэй. Шведийн хуульд үзэн ядалтын үг хэллэг болон хүчирхийлэлд уриалсан үйлдлийг хатуу хориглосон. **<u>Герман:</u>** Жагсаал, цуглааны тухай хуульд заасан оролцогчид, зохион байгуулагчдын үүргийн ханган биелүүлээгүй тохиолдлууд. Учир нь Герман улсад жагсаал, цуглааныг бүх үе шатанд нь хуулийн дагуу аюулгүй зохион байгуулахын тулд зохион байгуулагчид болон оролцогчид тус улсын хууль эрх зүйн орчин, түүнд заасан эрхийнхээ талаар мэдлэгтэй байх шаардлагатай байдаг. **<u>БНСУ:</u>** Дараах жагсаал, цуглааныг хэн ч хийж болохгүй: 1.Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр татан буугдсан улс төрийн намын зорилгод хүрэхийг оролдсон жагсаал, цуглаан; болон 2. Хамтын хүчирхийлэл, заналхийлэл, устгах, галдан шатаах зэргээр өдөөн хатгаж, нийтийн амгалан тайван байдал, дэг журамд шууд заналхийлсэн нь тодорхой болсон цуглаан, жагсаал. (2) Хэн ч (1)-д заасны дагуу хориглосон ийм жагсаал, цуглааныг суртал ухуулгын кампанит ажил явуулахгүй, эсхүл ийм цуглаан хийх, жагсаал зохион байгуулахад хүмүүсийг турхирч болохгүй.
Олон нийтийн аюулгүй байдлыг хангах	**<u>Швед:</u>** Олон нийтийн аюулгүй байдалд заналхийлэхүйц үйл ажиллагаа гэж үзвэл Шведийн эрх баригчид уг жагсаалыг хориглох эрхтэй. Тухайлбал, хэт даврагч бүлгүүдээс зохион байгуулж буй жагсаал нь олон нийтийн тайван байдлыг алдагдуулах эрсдэлтэй бол хориглож болно. Цар тахал зэрэг эрүүл мэндийн онцгой нөхцөл байдлын үед олон хүн цугларах нь халдварыг тараах эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд жагсаал цуглааныг хязгаарлаж эсвэл хориглож болно. Олон нийтийн дэг журам, амар тайвныг алдагдуулж болзошгүй тохиолдолд эрх баригчид уг жагсаалыг хязгаарлах боломжтой. Жагсаал нь эмх замбараагүй байдал үүсгэх, халдах, эд хөрөнгө сүйтгэх зэрэг нөхцөл байдал үүсгэхээр бол уг арга хэмжээг хориглоно. **<u>Герман:</u>** Зэвсэг хэрэглэхээс зайлсхийх, зөвхөн эрүүл мэндийн зайлшгүй шалтгаантай л биш бол амны хаалт зүүхийг хориглох гэх зэрэг аюулгүй байдлын үүднээс дагаж мөрдөх дүрэм журмуудтай. Мөн ямарваа хүчирхийллийн шинж чанартай үйл үйлдэл ажиглагдсан даруйд тухайн жагсаалыг тайван жагсаал биш гэж үзэн тараах үндэслэл үүснэ. Ийнхүү жагсаал, цуглаантай холбогдох дүрэм журмуудыг зөрчихийг олон нийтийн аюулгүй байдалд нөлөөлөх нөхцөл болно гэх үндэслэлээр тухайн жагсаал, цуглааныг тараах үндэслэл болдог байна. Жагсаал, цуглааныг төлөөлөн удирдаж буй хүмүүс нь хууль сахиулах байгууллагатай харилцаж, хамтран ажиллах харилцааг хариуцна. Цагдаа хүчний байгууллагын үйл ажиллагаа, эрх зөрчигдсөнтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд нотлох баримт бүрдүүлэхийн тулд камер гэх зэрэг зохих тоног төхөөрөмжийг ашиглан жагсаал цуглааны үйл ажиллагааг бичиж

	баримтжуулна. **БНСУ:** Жагсаал, цуглаан зохион байгуулагчид хориглосон үйлдлийг хуульд заахдаа олон нийтийн аюулгүй байдалтай холбоотой асуудлуудыг багтаажээ: 1.Бусдын амь нас, бие махбодийн аюулгүй байдалд аюул, хохирол учруулж болзошгүй галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, сэлэм, төмөр баар, саваа, чулуу, бусад хэрэгслийг авч явах, ашиглах, эсхүл бусдад авч явах, ашиглахыг шаардах; 2.Хүчирхийлэл, заналхийлэл, устгал, галдан шатаах зэргээр эмх журам зөрчих. Мөн дотор цуглааныг зохион байгуулагч нь чанга яригч суурилуулах гэх мэтээр эргэн тойрныхоо хүмүүсийн оролцоог татахуйц аливаа үйлдлийг хийх ёсгүй гэж зохицуулсан байна.
Зохион байгуулалтын журам зөрчсөн гэж үзэх	**Швед:** Жагсаал зохион байгуулахын тулд тодорхой цаг хугацааны өмнө цагдаагийн байгууллагад мэдэгдэх шаардлагатай. Хэрэв зохион байгуулагчид уг журмыг зөрчвөл, эрх баригчид жагсаалыг хориглож эсвэл хязгаарлаж болно. **Герман:** Жагсаал, цуглааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар олон нийтийн жагсаал, цуглааныг задгай талбайд зохион байгуулах гэж байгаа бол зохион байгуулагч нь жагсаал, цуглааныг зарлахаас багадаа 48 цагийн өмнө эрх бүхий байгууллагад мэдэгдэх ёстой байдаг. Мөн дээр дурдсанчлан жагсаал, цуглаанд оролцогчид, эрх үүргээ сайн мэдсэн байх шаардлагатай. Хэрвээ тэд жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцохдоо үүргээ сайн биелүүлэхгүй бол хууль зөрчсөнд тооцогдоно. **БНСУ:** Жагсаал, цуглааны үед оролцогчдын болон бусад иргэдийн аюулгүй байдлыг хангахад зохион байгуулагчид, зохицуулагчид, оролцогчид ихээхэн хариуцлага ногдуулж, хэрвээ зохион байгуулагч цуглаан, жагсаалыг эмх цэгцтэй явуулж, дэг журмыг сахиулж чадаагүй тохиолдолд тэр цуглаан, жагсаалыг тараахаар (16.3-т) зохицуулсан байна. Жагсаал, цуглаан зохион байгуулагчид хориглосон үйлдлийг заасан хуулийн заалтуудын дотор, “Зорилго, огноо, цаг, газар, арга гэх мэтийг илт зөрчсөн үйлдэл гаргах” гэж зохицуулсан байна.
Хориглох байршил	**Швед:** Нийтийн аюулгүй байдалд нөлөөлөх газруудад жагсаал цуглааныг хязгаарлах боломжтой. Үүнд, эмнэлэг, сургууль, цэргийн бааз зэрэг газрууд орно. Цэргийн зориулалттай газрууд, баазуудын ойролцоо жагсаал хийхийг хориглодог. Мөн хотын төвийн тодорхой хэсэгт, зам тээврийн хөдөлгөөнд ихээхэн саад учруулах байршлуудад, тухайлбал гол зам, гүүр, нийтийн тээврийн зогсоол зэрэг газруудад хязгаарлалт тавьж болно. **Герман:** Жагсаал, цуглааны тухай хуулийн 15.2.1-т Үндсэрхэг үзэлт нийгмийн хүчирхийлэл, дур зоргоороо дэглэмийн үеийн хүнлэг бус харгислалын хохирогчдод зориулсан түүхэн онцлогтой, дурсгалт газарт жагсаал, цуглаан хийхийг хориглосон. Үүнд, Европт хөнөөгдсөн еврейчүүдийн дурсгалд зориулсан Берлин дэх газар зэрэг хамаарах бөгөөд бусад үүнтэй адил газар, тэдгээрийн хамгаалалтын бүсийг муж улсын хуулиар тогтоодог байна. **БНСУ:** Жагсаал, цуглаан хийх мэдэгдэлтэй холбоотойгоор: “нэг газар нэгэн зэрэг, ижил эсвэл зөрчилдсөн зорилготой жагсаал, цуглаан зохион байгуулах 2 болон түүнээс дээш мэдэгдэл ирүүлсэн бол сүүлд хүлээн авсан мэдэгдлийн жагсаал, цуглаан хийхийг хориглоно. 1. Мэдэгдэлд заасан газар (цаашид "мэдээлсэн газар" гэх) нь суурьшлын бүс буюу түүнтэй адилтгах газарт жагсаал, цуглаан хийх нь хувийн өмч, байгууламж, оршин суугчдын хувийн орон зайд ноцтой халдах, хохирол учруулж болзошгүй тохиолдолд; 2. Мэдээлсэн газар нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлд заасан сургуулийн эргэн тойронд байгаа газар тул жагсаал, цуглаан нь суралцах эрхийг ноцтой зөрчих магадлалтай бол; 3. Мэдээлсэн газар нь Цэргийн бааз, байгууламжийг хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу цэргийн байгууламжийн ойролцоо байх, жагсаал, цуглаан хийх нь цэргийн байгууламж, цэргийн ажиллагаа

	явуулахад ноцтой хохирол учруулж болзошгүй тохиолдолд. Жагсаал цуглааны тухай хуулийн 11 дүгээр зүйл (Гадаа цуглаан, жагсаал хийхийг хориглосон газар)-д шууд хориглохоор заасан газрууд нь: “Дараах оффисын барилга, орон сууцнаас 100 метрийн радиус дотор жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглоно. Үүнд: 1. Үндэсний Их Хурлын байр, бүх шатны шүүх, Үндсэн хуулийн цэц; 2. Ерөнхийлөгчийн өргөө болон Улсын Их Хурлын дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн цэцийн даргын албан ёсны өргөө; 3. Ерөнхий сайдын албан ёсны оршин суух газар; болон 4.Солонгос дахь дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнүүдийн оршин суух газар” гэжээ.
Хориглох хугацаа	**Швед:** Хэрэв жагсаал, цуглаан нь олон нийтийн амар тайван байдалд хэтэрхий удаан хугацаагаар сөрөг нөлөө үзүүлэхээр бол хугацааны хязгаарлалт хийнэ. Ингэхдээ орон нутгийн захиргаанаас тодорхой цагийн хязгаарыг зааж, шөнийн цагт, эсхүл тодорхой өдрүүдэд жагсаал хийхийг хориглох боломжтой. **Герман:** Жагсаал, цуглааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар олон нийтийн жагсаал, цуглааныг задгай талбайд зохион байгуулах гэж байгаа бол зохион байгуулагч нь жагсаал, цуглааныг зарлахаас багадаа 48 цагийн өмнө эрх бүхий байгууллагад мэдэгдэх ёстой байдаг. Ийнхүү хуулиар заасан хугацаанаас бага хугацаанд жагсаал, цуглаан зохион байгуулж болохгүй. **БНСУ:** Нар мандахаас өмнө, жаргасны дараа хэн ч гадаа жагсаал, цуглаан хийж болохгүй: Цагдаагийн эрх бүхий байгууллагын дарга нар мандахаас өмнө, бүр жаргасны дараа зохион байгуулагч нь уг цуглааныг зохион байгуулах талаар урьдчилан мэдээлсэн, тухайн арга хэмжээний мөн чанар нь тухайн цагуудад зохион байгуулах зайлшгүй бол дэг журам сахиулахаар гадаа цуглаан хийхийг зөвшөөрч болно (....хуулийн “Гадаа цуглаан, жагсаал хийхийг хориглох тухай” 10 дугаар зүйл).

Жагсаал, цуглааны тухай хууль, журам зөрчигчдөд ногдуулах хариуцлага:

Улс орнуудын жишигт жагсаал, цуглаан хийхийг хориглох, хязгаарлах тохиолдлуудыг хуульд тодорхой зохицуулсны зэрэгцээ уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд хэрхэн шүүхэд хандах тухай зохицуулалтуудыг мөн тусгасан байна.

Судалгаанд авагдсан улс орнуудад (ХБНГУ) иргэдийн тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийг хамгаалж субъектийн хувьд [хууль, журмын дагуу зохион байгуулагдаж буй] жагсаал, цуглаанд хөндлөнгөөс оролцсон, хүч хэрэглэн тараасан этгээдийг нэг жил хүртэлх хугацаагаар хорих ялаар шийтгэх хариуцлага ногдуулж байна.

Мөн эдгээр улсуудад хориглосон газар болон хориглосон хэлбэрээр жагсаал, цуглаан зохион байгуулсан этгээдэд 440 доллараас 2700 евро хүртэлх хэмжээгээр мөнгөн торгууль ногдуулж байна. Харин нийтийн эмх замбараагүй байдал үүсгэх замаар бусдын бие махбодид халдсан этгээдийг 5-7 хүртэлх жилээр, бусдын өмч хөрөнгөд халдсан бол 5 жил хорих ялаар тус тус шийтгэдэг байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ. ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ НИЙТЛЭГ ЗОХИЦУУЛАЛТ

1.1.ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Жагсаал, цуглаан хийх эрх нь тайван замаар жагсаж, цуглах эрх юм. Энэ нь хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхэд хамаарах бөгөөд ардчилсан тогтолцооны гол тулгуур аж. Жагсаал, цуглаан хийх гэдэг нэр томьёог XVIII зууны дунд үеэс хойш хэрэглэж эхэлсэн байна.

Жагсаал (англиар-demonstration) нь иргэд хот суурины гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлага илэрхийлэх хэлбэр юм.[2]

Цуглаан (англиар-assembly) нь иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагаа бөгөөд тайван цуглаан нь үзэл бодлоо илэрхийлэх, нийтлэг эрх ашгийг хамгаалах зэрэг олон зорилготой байж болдог.[3] Мөн цуглах эрх чөлөө нь иргэний бусад эрхээ эдлэхэд тусалдаг тул Үндсэн хуульд заасан бусад эрхүүдийг бодитой биелүүлэхэд ихээхэн ач холбогдолтой.

Хууль эрх зүйн орчин:

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь олон улсын хүний эрхийн бүх гол баримт бичигт тусгагдсан байдаг. Үүнд[4]:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйл (1948);
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйл (1966);
- Хүний эрх, үндсэн эрх чөлөөний тухай Европын конвенцын 11 дүгээр зүйл (1950);
- Ардчилсан засаглал ба тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай Хамтарсан Тунхаглал (2020);

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 20 дугаар зүйлд “хүн бүр чөлөөтэй тайван замаар сайн дураар хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй” хэмээн заасан байх бөгөөд 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21 дүгээр зүйлд “Тайван замаар хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө” гэжээ. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй” хэмээн тус хүний эрхийн үндсэн

---

[2] С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, (УБ, 2021), 142 дахь тал.
[3] О.Мөнхсайхан, “Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018 он No1, 15-28 дахь тал.
[4] https://www.gic.mn/post/147

гэрээнүүдэд зааснаас гадна энэхүү эрх, эрх чөлөөг бүс нутгийн хүний эрхийн гэрээ, улс орнуудын Үндсэн хуульд тодорхой зааж баталгаажуулсан байдаг.[5]

Хууль, тогтоомжийн чанарыг үнэлэх:

Жагсаал, цуглааны тухай хууль тогтоомжийн чанарыг үнэлэхдээ хэд хэдэн хүчин зүйлсийг авч үзнэ. Эдгээр хүчин зүйлст тухайн улсын хууль, практик, хүний эрхийн хамгаалалт зэрэг олон талын асуудлыг хамаарах бөгөөд нийтлэг болон үнэлгээний шалгууруудад үндэслэн үнэлж байна. Үүнд, дараах хүчин зүйлсийг голлон анхаарч байна:

1.**Хууль ёсны эрх**: Жагсаал, цуглаан зохион байгуулах эрхийг хэрхэн баталгаажуулж буйг нь шинжлэн үзнэ. Үүнд, хамгийн гол нь иргэдийн энэ талын эрх, эрх чөлөөг хязгаарлахгүй байх, хууль зөрчихгүйгээр жагсаал, цуглаан хийх боломжийг олгодог эсэх;.

2.**Зохицуулалтын нээлттэй байдал**: Жагсаал, цуглаан зохион байгуулахад шаардагдах зөвшөөрлийг хэрхэн авах, албан мэдэгдэл, мэдээллийг хэрхэн өгөх гэх зэрэг процедурыг хэр зэрэг боловсронгуй, нээлттэй байдлаар зохицуулсан эсэх;

3.**Хүний эрхийн хамгаалалт**: Жагсаал, цуглаан зохион байгуулах эрхийг хамгаалах хууль, хуулийн хэрэгжилтийн практик нь хүний эрхийг хэр зэрэг хамгаалан баталгаажуулдаг;

4.**Цэрэг, цагдаагийн болон аюулгүй байдлыг хангах тухай зохицуулалт**: Жагсаал, цуглааны үеэр аюулгүй байдлыг хэрхэн хангах, аливаа хүчирхийлэл, хэт даварсан үйл ажиллагаанаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх зохицуулалт нь ямар байгааг нягтлах;

5.**Шаардагдах стандартууд**: Жагсаал, цуглаан зохион байгуулах явцад тавигдах үндсэн стандарт, нөхцөлүүдийг хангаж буй эсэх;

6.**Тусгай хязгаарлалт**: Жагсаал, цуглаанд хязгаарлалт, хориг тавих нөхцөлүүд, онцгой байдлын үед жагсаал, цуглаан зохион байгуулах эрх, эрх чөлөөг хязгаарлах хуулийн зохицуулалтуудын талаар;

7.**Иргэдийн оролцоо**: Жагсаал, цуглаан зохион байгуулахад иргэдийн оролцоо, санал бодлыг хэрхэн хүлээн авч, судлан үзэж байгаа талаар;

8.**Түүх, практик**: Тухайн улс орны иргэдийн жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрх, эрх чөлөөг ханган хэрэгжүүлэхтэй холбогдох түүх, практикийг судлах.

Эдгээр хүчин зүйлсийг шинжлэн үзэх үндсэн дээр улс орнуудын жагсаал, цуглааны тухай хууль тогтоомжийг үнэлж, хууль ёсны дагуу жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчинтой, хүний эрхийг эрхэмлэн хамгаалдаг улс орон мөн эсэхийг нь тодорхойлж байна. Энэ үнэлгээг гаргахад олон улсын байгууллагууд, хүний эрхийн байгууллагууд, судлаач, мэргэжилтнүүдийн дүгнэлт чухал нэг үндэслэл нь болдог байна.

[5] Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага, https://www.osce.org/files/f/documents/b/7/524223.pdf

Жагсаал, цуглааны төрлүүд: Тайван жагсаал, цуглаан хийх эрхэд хамаарах олон нийтийн цугларалтын олон янзын хэлбэр байдаг. Эдгээр нь хурал, цуглаан, хаалт, жагсаал, явган жагсаал, ёслол, парад, гэнэтийн цугларалт буюу флаш моб зэрэг болно. [6]

Тайван жагсаал, цуглаан нь зохион байгуулагчдын санаа, зорилго тайван, оролцогчдын зан байдал тайван амгалан байвал уг жагсаал, цуглааныг тайван гэж үздэг.

Аяндаа бий болдог жагсаал, цуглаан нь аливаа зөрчил, үйл явдалд хариу үйлдэл үзүүлэх байдлаар зохион байгуулагддаг жагсаал, цуглаан бөгөөд хуульд заасан "урьдчилан мэдэгдэх ёстой" гэсэн шаардлагыг биелүүлэх боломжгүй, эсвэл албан ёсоор хариуцсан зохион байгуулагч байдаггүй ажээ. Энэ төрлийн жагсаал, цуглааны оролцогчдын тоо санамсаргүй байдлаар хүмүүс цугларч эхэлмэгц харилцаа холбооны янз бүрийн хэлбэр (утас, мессеж, амнаас ам дамжих, интернет, нийгмийн сүлжээ г.м.)-ээр мэдээлэл түгсэнээр, маш хурдацтай жагсаал, цуглаан болон өргөжиж, өрнөж болдог байна.

Жагсаал, цуглааны үеийн хамгаалалт: Олон улсын хүний эрхийн зарчмуудад төр, түүний төлөөлөгч нь хүний бүх эрхийг хүндэтгэж, хамгаалах үүрэг, хариуцлага хүлээдэг.

Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хамгаалах нь нийгмийн янз бүрийн бүлгүүд хамтдаа энх тайвнаар оршин тогтнох хүлээцтэй, олон ургальч нийгмийг бий болгоход маш чухал болохыг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд онцолсон байна.

Жагсаал, цуглаан хийх эрхийг хэрэгжүүлэхэд уг эрхийг хамгаалах, зохицуулах үндсэн үүрэг нь нийтийн хэв журмыг сахиулах эрх бүхий байгууллага болох цагдаагийн байгууллагад оногддог. Үүнд, өдөр тутмын үйл ажиллагаа, ялангуяа жагсаал, цуглаанд оролцогч бус энгийн иргэдийн амьдралд тодорхой хэмжээгээр саад учруулж болзошгүй өдөөн хатгасан, доромжилсон өнгө аястай тайван жагсаал, цуглааны үеэр ч тэдгээр иргэдийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг сахин хамгаалах үүрэг хариуцлага багтаж байна.

"Тайван жагсаал, цуглаан" гэсэн тодорхойлолтод хамаарах тохиолдолд аяндаа бий болсон жагсаал, цуглааныг урьдчилж мэдэгдсэний дагуу хийж байгаа жагсаал, цуглаантай ижил түвшинд үзэж аюулгүй байдлыг нь хангах ёстой гэж үздэг.

Олон улсын гэрээ, зөвлөмжүүдэд ИНБ-ууд бодлого боловсруулах үйл явцад биечлэн оролцох боломжгүй, оролцоо дутмаг үед цахим хэлэлцүүлгээр дамжуулан оролцуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх, аль ч тохиолдолд цахимаар тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хувь хүний нууцыг хамгаалан хүндэтгэсэн хэлбэрээр ханган баталгаажуулахыг улс орнуудад зөвлөжээ.[7]

Жагсаал, цуглааныг хязгаарлах: [8] Тайван жагсаж, цуглах эрх, эрх чөлөөг хамгаалан баталгаажуулах, дэмжих нь төрийн үүрэг боловч үндэсний аюулгүй байдал болон олон нийтийн амгалан тайван байдал, нийтийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд болон бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах гэх зэрэг зайлшгүй үндэслэл, шаардлагын улмаас жагсаал, цуглааныг хязгаарладаг тохиолдлууд бий.

---

[6] https://www.osce.org/files/f/documents/b/7/524223.pdf

[7] https://sudalgaa.gov.mn/LELLtP

[8] https://www.osce.org/files/f/documents/b/7/524223.pdf

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 21-р зүйлд жагсаал, цуглааныг хязгаарлах үндэслэлийг дараах байдлаар заажээ. Үүнд: “Аливаа ардчилсан нийгэмд энэ эрхийг хэрэгжүүлэхэд үндэсний аюулгүй байдал, нийтийн амгалан тайван байдал, төр нийгмийн байгуулал, нийтийн эрүүл мэнд, ёс суртахуун, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах тухай хуулийн заалтууд, мөн нийтийн эрх ашгийг хамгаалах ашиг сонирхол зэрэг зайлшгүй шаардлагуудтай нийцүүлэн хуулиар тогтоосноос бусад ямарваа хязгаарлалт тавьж болохгүй” гэж заасан байдаг.

Хязгаарлалтыг жагсаал, цуглаан болохоос өмнө, жагсаал, цуглааны үеэр, эсвэл аль алинд нь тавьж болно. Зарим улсад жагсаал, цуглаан болохоос өмнө цагдаагийн байгууллага хязгаарлалт тогтоох үүрэг хүлээдэг бол, зарим улс оронд энэ эрх мэдэл нь орон нутгийн засаг захиргаа, шүүх гэх мэт эрх мэдэл бүхий өөр байгууллагад байдаг байна.

Жагсаал, цуглааныг хориглох: Жагсаал, цуглааныг дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал үүсгэх буюу үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бусаар булаан авахыг уриалах, үндэсний аюулгүй байдал, төр нийгмийн байгуулалд ноцтой хохирол учруулж, эмх замбараагүй байдал үүсгэх зорилгоор зохион байгуулах, оролцохыг хориглодог.

Тэгэхээр төрөөс ард иргэдийнхээ жагсаал, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг үндсэн эрхээ эдлэх хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрөхийн сацуу эдгээрийг хэрэгжүүлэх арга хэлбэр, хүрээ, дэг журмыг хуулиар нарийн сайн тогтоож зохицуулах шаардлагатай болдог байна. Дэлхийн улс орнуудад жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөг зөвшөөрлийн болон бүртгэлийн гэсэн хоёр үндсэн тогтолцоогоор дамжуулан хангаж, хэрэгжүүлж байна.

Цахим жагсаал, цуглаан (Цахимаар эвлэлдэн нэгдэж, үзэл бодлоо илэрхийлэх):

Орчин үед цахим сүлжээ, техник технологи өндөр хөгжсөн, мөн ковид-19 цар тахлын улмаас иргэдийн цахим хэрэглээ өссөнтэй холбоотойгоор цахимаар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх явдал түгээмэл болсон.

Үүнтэй холбоотой НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын газар, Америк дундын Хүний эрхийн Комисс, Иргэдийн болон хүний эрхийн Африкийн комисс (ACHPR), ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн ажлын алба (ODIHR)-аас 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдөр “Ардчилсан засаглал ба тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай Хамтарсан Тунхаглал”-ыг [9] баталжээ. Уг Хамтарсан Тунхаглалд дурдсанаар тайван жагсаал, цуглаан хийх эрх нь цахим орон зай, мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглахад мөн хамаардаг байна. Тиймээс аливаа тохиолдолд цахимаар тайван жагсаал, цуглаан хийх эрхийг бүх талаар баталгаажуулан хэрэгжүүлэх ёстой байна.

Мөн үүгээр улс орнуудад нийгмийн сүлжээг хянах, харилцаа холбооны технологид суурилан хяналт тавих, тайван жагсаал, цуглаанд оролцогсдын мэдээллийн санг бүрдүүлэх зэрэг цахимаар цугларах эрхийг хязгаарласан элдэв арга хэмжээнээс татгалзахыг зөвлөжээ.

Бодлого боловсруулах үйл явцад ИНБ-ууд биечлэн оролцох боломжгүй, оролцоо дутмаг үед цахим хэлэлцүүлгээр дамжуулан оролцох боломж нөхцөлийг бүрдүүлж өгөх нь

[9] https://www.gic.mn/post/r/1651

иргэдийн цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулах чухал хэлбэр гэж үзжээ.

1.2. МОНГОЛ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ[10]

Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөө нь Үндсэн хуульд заасан бусад эрхүүдийг бодитой биелүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсад жагсаал, цуглаан зохион байгуулахтай холбоотой асуудлыг “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль”-аар зохицуулдаг. Тус хууль нь 1994 онд батлагдсан бөгөөд нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Тус хуульд “Монгол Улсын иргэдээс улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг **цуглаан** гэнэ. Иргэд хот суурингийн гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг **жагсаал** гэнэ” гэж тодорхойлжээ.

Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх:

- Жагсаал, цуглааныг Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй.
- Хууль Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд оролцох эрхтэй.

Жагсаал, цуглаан хийх эрхийн баталгаа:

- Хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан буюу түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр гадуурхахыг хориглоно.
- Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд жагсаал, цуглаан хийхэд зориуд саад учруулах, түүнчлэн хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг тараахыг хориглоно.

Жагсаал, цуглаан хийхийг хориглох иргэн, хуулийн этгээд:

- Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагч төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараахыг хориглоно.
- Засгийн газрын харьяа яам, агентлаг жагсаал цуглаан хийх, ажил хаялт, өлсгөлөн, суулт зарлах зэрэг улс төрийн болон шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Жагсаал, цуглаан хийхийг хориглох газар:

- нисэх онгоцны буудал, төмөр замын бүх өртөө, буудал, нийслэлийн зорчигч тээврийн төв буудал;

[10] Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail/252

- цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалалтад байгаа газар;
- радио телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгууллага, аймаг, нийслэл дэх төв холбооны газар;
- олон улсын буюу үндэсний яармаг, үзэсгэлэн зохион байгуулж байгаа байгууллага, хот суурин газрын хүнсний болон барааны зах;
- эмнэлгийн байгууллага;
- Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт */Төрийн ордны 30 метр газар хүртэлх/*

Дараах зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглоно:

- дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа,хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах;
- үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох.
- жагсаал, цуглааны явцад түүний зорилго өөрчлөгдөж дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа,хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах агуулга, шинжтэй болбол уг жагсаал, цуглааныг цаашид үргэлжлүүлэхийг хориглоно.
- Улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, гамшиг болон аюул тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилтал жагсаал, цуглаан хийхийг хориглоно.
- Онц болон дайны байдал зарласан шалтгааныг эсэргүүцэх, гамшгийн хор уршгийг арилгах зорилгоор зохион байгуулах цуглаанд энэ зүйлийн 3 дахь хэсгийн заалт үл хамаарна.
- Зохих журмын дагуу бүртгэгдсэн жагсаал, цуглаан хийх газарт мөн цаг хугацаанд түүний эсрэг агуулга, зорилготой өөр жагсаал, цуглаан давхардуулан хийхийг хориглоно.
- Гудамж, талбайд өлсгөлөн зарлахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулахыг хүний амь нас, эрүүл мэндийг үл хайхарсан хүмүүнлэг бус үйлдэл гэж үзэж хориглоно.
- Төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан, өлсгөлөн, суулт хийх зэргээр шаардлагаа илэрхийлэх, Төрийн ордонд нэвтрэгчид саад хийх.

Жагсаал, цуглааныг бүртгүүлэх:

Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.

Асуудлыг шийдвэрлэх дараалал:

- Жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэлд түүний зорилго, эхлэх, дуусах хугацаа, оролцогчдын баримжаа тоо, хэрэглэх техник хэрэгсэл, цуглах, жагсан явах гудамж, талбай зэргийг тодорхой заана.
- Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор түүнийг бүртгэсэн эсэхээ бичгээр мэдэгдэнэ.
- Жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэхийн тулд нэмж тодруулах буюу зохицуулбал зохих асуудал гарвал Засаг дарга 3 хоногийн дотор зохион байгуулагчтай харилцаж зохицуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд жагсан явах чиглэлийг өөрчлөх эрхтэй.
- Засаг дарга 3 хоногийн дотор хариу мэдэгдээгүй бол зохион байгуулагч нь мэдэгдэлд дурдсан газарт, түүнд заасан хугацааны дотор жагсаал, цуглааныг зохион байгуулах эрхтэй.
- Шүүхийн болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогсоогдсон буюу татан буугдсан, эсхүл албан ёсны бүртгэлгүй улс төрийн нам, төрийн бус байгууллага жагсаал, цуглаан хийх мэдэгдэл гаргасан бол Засаг дарга түүнийг хийхийг бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргавал 3 хоногийн хугацаанд жагсаал, цуглаан зохион байгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

Жагсаал, цуглааны үед нийгмийн хэв журмыг хамгаалах:

- Нийгмийн хэв журам хамгаалах үүрэг бүхий байгууллага нь хуульд заасан журмын дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны үед хэв журам хамгаалж, түүнд оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах үүрэгтэй.
- Жагсаал, цуглааны явцад хэв журам хамгаалах нэмэгдэл арга хэмжээ шаардлагатай бол зохион байгуулагч нь энэ тухай хүсэлтээ цагдаагийн байгууллагад гаргана.
- Жагсаал, цуглаан зохион байгуулагч болон оролцогчид нь хэв журам, хууль ёсыг сахих талаар цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- Жагсаал, цуглаанд оролцож байгаа авто хөсгийн хөдөлгөөнийг тусгайлан зохицуулна.

Жагсаал, цуглаан хийхтэй холбоотой гомдол гаргах:

Жагсаал, цуглаан хийхийг бүртгэхээс татгалзсан шийдвэр хүлээн авсан зохион байгуулагч түүнийг хуульд нийцэхгүй байна гэж үзвэл гомдлоо уг шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор шүүхэд гаргана.

Шүүгч жагсаал, цуглаан хийхийг бүртгэхээс татгалзсан засаг даргын шийдвэрийг хүчингүй болгосон бол зохион байгуулагч нь шүүгчийн захирамжийг хүлээн авсны дараа энэ тухай тухайн Засаг даргад урьдчилан мэдэгдэж жагсаал, цуглаан хийх цаг, хугацааг тохиролцож төлөвлөсөн арга хэмжээгээ зохион байгуулж болно. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тус тус зохицуулсан байна. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсаал, цуглааныг зохион байгуулах, бүртгүүлэх, жагсаал, цуглааны хэлбэрүүд болох сөрөг жагсаал, аяндаа үүссэн жагсаал, цуглааны талаарх хуулийн зохицуулалт байхгүйгээс гадна жагсаал, цуглааныг зохион байгуулагчид үүрэг ногдуулсан байдал нь иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах, эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ БА ЦАХИМ ЖАГСААЛ, ЦУГЛААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. ШВЕДИЙН ХААНТ УЛС

Шведийн Хаант Улс нь үндсэн хуульт хаант засаглалтай парламентын ардчилсан улс юм. Тус улсын Үндсэн хууль нь дөрвөн хэсгээс бүрдэх бөгөөд түүний нэг нь "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль"[11] юм. Энэ хууль нь "Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль"[1]-тай хамт Үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан хийх (*үг хэлэх, бичих, дүрсээр болон бусад хэлбэрээр мэдээлэл дамжуулах, бодол санаа, үзэл бодол, мэдрэмжээ илэрхийлэх эрх чөлөө, цуглаан*) эрх чөлөөг Үндсэн хуулиар хамгаалдаг.

Үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, жагсаал цуглаан хийх эрх чөлөө нь ардчиллын гол эрхүүд бөгөөд жагсаал цуглаан зохион байгуулах, оролцох эрхийг дараах эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулдаг:

- Шведийн Үндсэн хууль (Regeringsformen)
- Олон нийтийн цуглааны тухай хууль (Lag om allmänna sammankomster)
- Олон нийтийн тайван байдал болон дэг журмыг хамгаалах тухай хууль (Ordningslagen)
- Цагдаагийн тухай хууль (Polislagen)
- Эрүүгийн хууль (Brottsbalken)

Шведийн Үндсэн хууль (Regeringsformen): Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиар үг хэлэх, хэвлэлийн эрх чөлөө болон тайван жагсаал цуглаан хийх эрхийг хамгаалдаг. Үндсэн хуульд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, тайван жагсаал зохион байгуулах эрхийг хязгааргүй гэж үздэг боловч нийгмийн аюулгүй байдал, нийтийн дэг журамтай зөрчилдөхгүй байх нөхцөлтэй.

Олон нийтийн цуглааны тухай хууль (Lag om allmänna sammankomster): Энэхүү хууль нь олон нийтийн жагсаал, цуглааныг зохион байгуулах нөхцөл, журам, хязгаарлалтыг тодорхойлсон эрх зүйн баримт бичиг юм. Хуульд зааснаар олон нийтийн газар жагсаал, цуглаан хийхэд урьдчилан цагдаагийн газарт мэдэгдэж, зөвшөөрөл авах шаардлагатай.

Олон нийтийн тайван байдал болон дэг журмыг хамгаалах тухай хууль (Ordningslagen): Олон нийтийн газар зохион байгуулагдах үйл ажиллагаа нь нийтийн дэг журам, аюулгүй байдлыг зөрчөөгүй байхыг энэхүү хууль шаарддаг. Хэрэв жагсаал эсвэл цуглаан нь нийгмийн аюулгүй байдалд заналхийлж байвал цагдаа болон орон нутгийн захиргаа түүнийг хориглож, тараах арга хэмжээ авах эрхтэй.

Цагдаагийн тухай хууль (Polislagen): Цагдаагийн газар жагсаал, цуглааныг хянах, зохицуулах үүрэгтэй. Тэд иргэдийн эрхийг хамгаалахын зэрэгцээ нийтийн дэг журам болон аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Хэрэв жагсаалын явцад хууль бус үйлдэл гарах эсвэл эмх замбараагүй байдал үүсвэл цагдаагийн албан хаагчид жагсаалыг тараах эрхтэй.

---

[11] https://www.riksdagen.se/ Шведийн Үндсэн хууль, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Олон нийтийн тайван байдал болон дэг журмыг хамгаалах тухай хууль, Дотоодын мэдээллийн хамгаалалтын хууль, Цагдаагийн тухай хууль, Эрүүгийн хууль.

Эрүүгийн хууль (Brottsbalken): Энэ нь үзэн ядалт, гүтгэлгээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хамгаалах, нийгмийн эв нэгдлийг хангахад чиглэгдсэн чухал хуулиудын нэг юм. Арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа болон бусад шинж чанараар хүмүүсийг ялгаварлан гадуурхахыг өдөөн турхирсан аливаа хэл яриа, заналхийлэл нь гэмт хэрэг (Hets mot folkgrupp) гэж тооцогддог. Гүтгэлэг гэдэг нь бусдын нэр хүндийг гутаах, худал мэдээлэл тараахыг хэлнэ. Энэ нь хувийн болон олон нийтийн мэдээлэл тараасан эсэхээс хамааран өөр өөр хариуцлага хүлээлгэнэ. Хувь хүний нэр хүндэд хор учруулсан гэмт хэрэгт мөн торгууль, шүүхээр шийтгэл оноодог. Хэрэв гүтгэлэг нь олон нийтэд тараагдсан бол илүү хүнд ял шийтгэл оноох боломжтой.

Энэ мэтчилэн хүн бүрийн үзэл бодлоо илэрхийлэх, олон нийтийн цугларалтад оролцох, жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох, мэдээлэл авах, дамжуулах, түгээх эрх болон түүнтэй холбоотой харилцааг Үндсэн хууль, түүний дагалдах хуулиудаар зохицуулж өгсөн.

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаас “жагсаал цуглаан хийх эрх чөлөөг аль болох хуулиар нарийвчлан зохицуулахаас зайлсхийж, бодитоор хэрэгжүүлэхэд ямар нэгэн зөвшөөрөл шаардахгүй байх” хэрэгтэй хэмээн үзжээ.[12]

Гэвч Швед Улсад ард иргэд, нийтийн аюулгүй байдлын үүднээс дээрх хуулиудаар зохицуулахын зэрэгцээ Үндсэн хуульд зааснаас бусад тохиолдолд (насанд хүрээгүй хүмүүст хамааралтай хязгаарлалт, хувь хүний нууц, г.м) эдгээр эрх чөлөөг хязгаарлахыг зөвшөөрөхгүй бөгөөд цензур тавих болон бусад саад учруулах аливаа үйл ажиллагааг хориглодог байна.

Цахим жагсаал, цуглаан зохион байгуулах эрх зүйн зохицуулалт, эерэг сөрөг үр дагавар

Швед Улсын хувьд цахим орчин дахь үйл ажиллагаа, үүнд цахим жагсаал цуглаан, цахим хэлэлцүүлэгтэй холбоотой тусгайлсан хууль байдаггүй ч, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх болон цахим орчны зохицуулалтыг хангах хууль, журмууд үйлчилдэг бөгөөд энэ нь цахим жагсаал, олон нийтийн хэлэлцүүлэгт хамааралтай асуудлуудыг зохицуулдаг. Хууль тогтоомжууд нь уламжлалт жагсаал цуглааны хуулийн үндсэн заалтуудтай ижил зарчмыг баримталдаг ба цахим орчинд үйлчлэх зохицуулалтыг мөн агуулдаг.

Эрх зүйн гол үндэслэл:

Үг хэлэх эрх чөлөө: Олон улсын болон үндэсний хууль тогтоомжууд, тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл, Европын Хүний Эрхийн Конвенцын 10 дугаар зүйл нь үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалдаг. Энэ нь цахим орчинд жагсаал, цуглаан зохион байгуулах эрхийг мөн хамаардаг.

Жагсаал, цуглаан хийх эрх: Жагсаал цуглаан хийх эрхийг Үндсэн хууль, хүний эрхийн баримт бичгүүдэд тусгасан байдаг. Жишээлбэл, Европын Хүний Эрхийн Конвенцын 11 дүгээр зүйл нь энхтайвны жагсаал хийх эрхийг баталгаажуулдаг. Олон улсад цахим хэлбэрт

[12] ЕАБХАБ/АХЭБ болон Венецийн Комисс, Тайван хуран цуглах эрхийн талаарх удирдамж, (2010), 30 дахь догол;

шилжсэн жагсаал цуглааныг энэ эрхтэй уялдуулж, зохицуулж байна.

Цахим орчны аюулгүй байдал: Олон оронд цахим жагсаал, цуглаантай холбоотой зохицуулалтад кибер аюулгүй байдал, цахим халдлагаас хамгаалах хууль багтдаг. Жишээлбэл, Шведэд цахим орчинд зохион байгуулж буй жагсаал, мэдээлэл солилцоо нь бусдын эрхэнд халдах, гүтгэх, үзэн ядалт үүсгэх үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн зохицуулалтууд байдаг.

Эрх зүйн үндсэн зохицуулалтууд:

1. Үндсэн хууль *(Regeringsformen)*:

Шведийн Үндсэн хуульд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулдаг бөгөөд энэ эрх нь зөвхөн физик орчинд бус цахим орчинд ч адил үйлчилнэ. Ингэснээр цахим жагсаал эсвэл олон нийтийн хэлэлцүүлэг нь Үндсэн хуулийн заалтуудын хүрээнд хамгаалагдана. Цахим жагсаал, хэлэлцүүлэгт оролцогчид хууль бус агуулга, үзэл бодол илэрхийлэхгүй байх үүрэг хүлээдэг.

2. Хэвлэлийн эрх чөлөөний хууль *(Tryckfrihetsförordningen*):

Энэ хууль нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим орчин дахь үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалдаг. Цахим жагсаал болон олон нийтийн хэлэлцүүлгийн үеэр илэрхийлсэн үзэл бодол энэ хуулийн хүрээнд хамгаалагдана.

3. Цахим харилцааны тухай хууль [13]*(Lag om elektronisk kommunikation)*:

Тус хуулиар цахим харилцаа, мэдээллийн аюулгүй байдлыг зохицуулдаг. Цахим жагсаал, онлайн хэлэлцүүлгийн үед үүсэх кибер аюулгүй байдал, хувийн мэдээллийн хамгаалалттай холбоотой асуудлуудыг энэ хууль зохицуулна.

4. Цагдаагийн тухай хууль[14] (Polislagen):

Шведийн хуулийн дагуу цахим орчинд үзэн ядалт, заналхийлэл тараах, бусдыг дарамтлах, гүтгэх үйлдлийг гаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Швед улсад цахим жагсаал цуглаан зохион байгуулах эрх зүйн зохицуулалт нь үндсэндээ үг хэлэх эрх чөлөө, жагсаал цуглаан хийх эрхтэй холбоотой байдаг. Шведийн Үндсэн хууль болон Хүний эрхийн тухай Европын конвенцын дагуу үг хэлэх эрх чөлөө, мэдээлэл олж авах, түгээх эрх нь баталгаажсан. Гэхдээ цахим жагсаал цуглаан зохион байгуулахад тодорхой дүрэм, журам болон зохицуулалт хэрэгжүүлдэг байна. Энэ нь ардчилсан зарчмуудыг дэмжихийн зэрэгцээ олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилготой.

Хүснэгт 2

Эерэг үр дагавар	Сөрөг үр дагавар
1.**Ардчиллыг дэмжих:** Цахим жагсаал, цуглаан нь иргэдэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгож, ардчилсан үйл явцад оролцох нөхцөлийг бүрдүүлдэг. 2.**Богино хугацаанд, өргөн хүрээнд оролцох боломж:** Орон зайн болон цаг хугацааны	1.**Хууль зүйн хязгаарлалт:** Цахим орчин дахь жагсаал, цуглаан нь хуулиар зохицуулагдсан, олон нийтийн аюулгүй байдал, хувийн нууцад халдах зэрэг эрсдэлтэй. 2.**Технологийн хүндрэл:** Олон хүн оролцож буй цахим жагсаал техникийн хувьд хүндрэлтэй

[13] https://pts.se/ Цахим харилцааны тухай хууль
[14] https://www.notisum.se/ Цагдаагийн тухай хууль

хязгаарлалтаас үл хамааран олон нийт цахим хэлбэрээр шууд оролцох боломжтой. Энэ нь илүү олон хүнийг татан оролцуулж, санал авч шийдвэр гаргахад ихээхэн нөлөөлнө. 3.**Зардал хэмнэлт**: Бодит жагсаал, цуглааны зохион байгуулалтаас илүү хямд бөгөөд хялбар арга хэмжээ болж, цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	байж, серверийн ачаалал, аюулгүй байдлын асуудал үүсгэж болзошгүй. 3.**Нийгмийн хуваагдал:** Цахим жагсаал, цуглаан нь сошиал медиагийн хэт туйлширсан хэлэлцүүлэг үүсгэж, нийгэмд хуваагдмал байдал үүсгэх магадлалтай.

Эдгээр эерэг, сөрөг үр дагавар нь Шведэд цахим жагсаал, цуглааныг зохион байгуулахдаа хууль ёсны хүрээнд байх, хариуцлагатай байх шаардлагатайг харуулж байна.

Жагсаал, цуглааны бүх үе шатыг хэрхэн хамгаалах

Шведэд жагсаал, цуглааны үеийн бүх үе шатанд хамгаалах зохицуулалттай бөгөөд үүнд оролцогчдын эрх, нийгмийн аюулгүй байдал, хууль ёсны ажиллагааг хамгаалах нь чухал юм. Эрх зүйн орчны хувьд Европын Хүний Эрхийн Конвенц болон НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал зэрэг олон улсын гэрээнд нэгдсэн улс тул жагсаал цуглааны эрхийг хамгаалах олон улсын стандартуудыг дагаж мөрддөг.

Олон нийтийн жагсаал цуглаан нь зохих зөвшөөрлийн дагуу энх тайван байдлаар явагдаж, оролцогчдын эрх хамгаалагдах нь Үндсэн хуулийн болон олон улсын гэрээнүүд, бусад хууль тогтоомжуудаар баталгаажсан тул бүх үе шатанд ардчилсан нийгмийн зарчмуудыг дээдэлсэн байдлаар хамгаалалтыг хэрэгжүүлэхээр зохицуулагдсан.

Шведэд жагсаал, цуглааны бүх үе шатыг хамгаалах эрх зүйн орчин нь хууль болон тогтолцоогоор зохицуулагдсан байдгаараа онцлогтой.

Шведийн “Олон нийтийн жагсаал цуглааны тухай”, "Олон нийтийн тайван байдлыг хамгаалах тухай" ("Lagen om skydd för samhällsfreden") хуулиуд нь жагсаал зохион байгуулах журам, шаардлагуудыг тодорхойлсон байдаг ба цагдаагийн байгууллага нь хууль тогтоомжийн дагуу хүн бүр үзэл бодлоо илэрхийлэх нөхцөл, жагсаал, цуглаанд тавигдах бодит шаардлагыг хангаж аюулгүй байдлыг хангах үүрэгтэй тул жагсаал цуглааны үеэр нийтийн хэв журам сахиулж аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд арга хэмжээ авах ёстой. Иймд тус байгууллага нь жагсаалыг зохион байгуулах үеэс эхлээд, түүний явц, дараах хамгаалалт хүртэл хуулийн дагуу арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг байна.[15]

Жагсаал цуглааны үед дараах үйл ажиллагаанд онцгойлон анхаарна. Үүнд:

Цагдаагийн газар болон олон нийтийн аюулгүй байдал

Шведэд жагсаалын үеэр цагдаагийн алба хаагчид олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, жагсаал энх тайван байдлаар үргэлжлэхэд хяналт тавих замаар хэрэгжүүлэг бөгөөд хэрэв ямар нэгэн эмх замбараагүй байдал үүсэх эрсдэл гарвал цагдаа нар арга хэмжээ авч болох ч жагсаал хийх эрхийг хүндэтгэх зарчим үргэлж үйлчилнэ.

Үзэн ядалт, хүчирхийлэлд уриалахаас хамгаалах [16]

[15] The Swedish Police Authority Strategy for Crime Prevention Work, 2022 он.
[16] Олон нийтийн цуглаан ба Шведийн аюулгүй байдал, Засгийн газрын судалгаа, 2024 он

Үзэн ядалт, хүчирхийллээс хамгаалах үйл ажиллагаа нь Олон нийтийн тайван байдал болон дэг журмыг хамгаалах тухай хууль, Цагдаагийн тухай хууль, Эрүүгийн хууль гэх мэт хуулиудаар хамгаалагдах ба Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний зөвлөл (Brå)[17] нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон судалгаа шинжилгээний ажлуудыг хийдэг байна.

Шведэд үзэн ядалтын үг хэллэг, хүчирхийлэлд уриалсан контентыг хатуу хориглодог. Энэ нь цахим орчин болон биечлэн зохион байгуулж буй жагсаал цуглаанд аль алинд нь хамаардаг. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хамгаалах ч бусдын эрхэнд халдсан, хүчирхийлэлд уриалсан үйл ажиллагаа явуулахыг хуулиар хатуу хориглодог байна.

Цахим жагсаал, цуглааны эрх зүйн хамгаалалт

Шведийн цахим жагсаал, нийгмийн сүлжээ болон онлайн платформ дахь үг хэлэх эрхийг ч биечлэн зохион байгуулдаг жагсаалын нэгэн адил Цахим харилцааны хууль, дээр дурдсан бусад хуулиуд болон тогтолцоогоор хамгаалдаг байна. Цахим жагсаалын хувьд оролцогчдын цахим орчинд үлдээсэн контент, хувийн мэдээлэл хамгаалагдсан байх ёстой. Цахим орчинд үзэн ядалтын үг хэллэг, гүтгэлгээс урьдчилан сэргийлэх хууль мөн үйлчилдэг.

Жагсаал, цуглааны үеийн гурван үе шатны хамгаалалт

Жагсаал цуглааны үе шатны хамгаалалт гэдэг нь жагсаалын бэлтгэлээс эхлээд, түүний явц, эцсийн үр дүн хүртэл оролцогчдын эрх, аюулгүй байдал болон хууль ёсны хамгаалалтыг хангах цогц арга хэмжээг хэлнэ. Швед улсын жагсаал, цуглааны бүх үе шатны хамгаалалт нь дараах байдлаар хэрэгждэг:

1. Жагсаалын өмнөх үе шатны хамгаалалт

Энэ үе шат нь жагсаалыг зохион байгуулах зөвшөөрөл авах, бэлтгэл ажлыг хангах, оролцогчдыг мэдээллээр хангах үйл явцаас бүрдэх ба хамгаалалтын тогтолцоо зэрэгцэн ажиллаж эхэлдэг.

Зохион байгуулалтын зөвшөөрөл: Жагсаал, цуглаан зохион байгуулахын тулд тодорхой хугацааны өмнө орон нутгийн цагдаагийн байгууллагад жагсаалын зорилго, цаг хугацаа, байршлын мэдээлэл зэргийг өгөх шаардлагатай байдаг ба үүнийг цахимаар болон бичгээр үйлдэж болно.

Цагдаагийн байгууллага жагсаалын аюулгүй байдлыг хангахын тулд зохих бэлтгэл ажлыг хийж, замын хөдөлгөөн, аюулгүй байдлын зохицуулалтыг урьдчилан боловсруулаад зөвшөөрөл олгоно.

Зохион байгуулагчдыг хамгаалах: Зохион байгуулагчид жагсаалыг зохих ёсоор явуулах, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй ч тэдний эрхийг ч мөн хамгаална.

2. Жагсаалын үеийн хамгаалалт

Жагсаалын явцад олон нийт болон оролцогчдын аюулгүй байдал тэдний эрхийг хамгаалах нь хамгийн чухал учир цагдаагийн алба хаагчид хяналт тавина.

Цагдаагийн хяналт: Жагсаалын үеэр цагдаа нар тайван жагсаал болох үйл явцыг хянаж, ямар нэгэн хүчирхийлэл, эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд арга хэмжээ авдаг.

[17] https://bra.se/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний зөвлөлийн албан ёсны цахим хуудас.

Гэхдээ тэд жагсаалын оролцогчдын эрхийг хүндэтгэн ажиллах үүрэгтэй.

Оролцогчдын эрхийг хамгаалах: Цагдаа болон бусад байгууллага жагсаалын явцад оролцогчдыг хэт хатуу хянах, эсвэл хууль бус үйл ажиллагаанд татан оруулахгүй байх үүрэгтэй.

Эмх замбараагүй байдалтай тэмцэх: Хэрэв жагсаалын явцад хүчирхийлэл, эмх замбараагүй байдал үүсэх нөхцөл байдал гарвал цагдаа нар арга хэмжээ авч болох ч хүч хэрэглэх нь хамгийн сүүлчийн арга байх ёстой. Чиг үүргийн байгууллагууд нь жагсаалыг аль болох энх тайвны замаар зохицуулан, оролцогчдын эрхийг хамгаалах үүрэгтэй байдаг.

3. Жагсаалын дараах хамгаалалт

Жагсаал цуглаан дууссаны дараа оролцогчид болон зохион байгуулагчдын эрх, аюулгүй байдлыг хамгаалах үйл явц үргэлжилнэ. Зохион байгуулагчид, оролцогчдын хувийн нууц болон аюулгүй байдлыг үргэлжлүүлэн хуулиар хамгаалдаг.

Оролцогчдын хувийн мэдээлэл, аюулгүй байдал: Хэрэв жагсаалын үеэр оролцогчдын хувийн мэдээллийг цуглуулан авсан бол түүнийг хууль ёсны дагуу ашиглах, хамгаалах шаардлагатай. Швед улс нь хувийн нууц хадгалах хуулиндаа хувь хүний мэдээллийг хамгаалах, тэдний нууцлалыг хангах зорилготой эрх зүйн зохицуулалтуудыг багтаасан байдаг. Энэ хүрээнд Швед улс Европын Холбооны Ерөнхий мэдээллийн хамгаалалтын журам (GDPR)-ыг мөрддөг бөгөөд үүнтэй нийцүүлэн өөрийн дотоод хууль, журмуудыг боловсруулсан.

- *Ерөнхий мэдээллийн хамгаалалтын журам (GDPR):* Энэ нь хувь хүний хувийн мэдээллийг боловсруулах, хамгаалах болон зүй зохистой ашиглахад чиглэсэн хамгийн чухал журам юм. Энэ журмаар хувь хүний мэдээлэл нь зөвшөөрөлгүйгээр боловсруулах ёсгүй бөгөөд тухайн иргэн өөрийн мэдээллийг хянах, засварлах, устгах эрхтэй.
- *Шведийн Дотоодын мэдээллийн хамгаалалтын хууль*[18]*(Dataskyddsförordningen):* Энэ нь Шведийн мэдээллийн хамгаалалтын хууль бөгөөд GDPR-ийн заалтуудыг үндэслэн Шведийн онцлогт тохируулан боловсруулагдсан. Уг хууль нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд хувь хүний мэдээллийг хэрхэн цуглуулж, хадгалж, ашиглах тухай заасан байдаг.

Цахим жагсаалын дараах хамгаалалт: Цахим жагсаалын хувьд оролцогчдын цахим орчинд үлдээсэн контент, хувийн мэдээлэл хамгаалагдсан байх ёстой. Мөн цахим орчинд үзэн ядалтын үг хэллэг, гүтгэлгээс урьдчилан сэргийлэх хууль үйлчилдэг.

4. Хуулийн хариуцлага: Жагсаалын явцад хууль бус үйлдэл гаргасан бол хуулийн дагуу хариуцлага хүлээлгэдэг.

Жагсаал цуглааныг хориглох (хугацаа, байршил, оролцохыг хориглох субъект)

Шведэд жагсаал цуглаан хийх эрх нь ардчилсан нийгмийн үндсэн зарчмуудын нэг гэж үздэг бөгөөд Шведийн Үндсэн хууль, Европын Хүний Эрхийн Конвенцын хүрээнд хамгаалагдсан

[18] https://www.lagboken.se/ Шведийн Дотоодын мэдээллийн хамгаалалтын хууль, (Dataskyddsförordningen)

байдаг. Гэхдээ зарим тодорхой нөхцөл байдалд жагсаал цуглааныг хориглох, хязгаарлах эрх зүйн үндэслэлүүд бий. Тодорхой нөхцөл байдалд төр засаг болон орон нутгийн захиргаа энэ эрхийг хориглох боломжтой.

Жагсаал, цуглааны тухай хууль ("Ordningslagen")-д эдгээр хориглолт, хязгаарлалтуудыг тодорхой зааж өгсөн (*2 дугаар бүлэг 6,15,25 дугаар зүйл*).

Хүснэгт 3. Жагсаал, цуглааныг хориглох гол үндэслэлүүд

Олон нийтийн аюулгүй байдал	Олон нийтийн аюулгүй байдалд заналхийлэхүйц үйл ажиллагаа гэж үзвэл Шведийн эрх баригчид уг жагсаалыг хориглох эрхтэй. Тухайлбал, хэт даврагч бүлгүүдээс зохион байгуулж буй жагсаал нь олон нийтийн тайван байдлыг алдагдуулах эрсдэлтэй бол хориглож болно.
Эрүүл мэндийн аюул	Цар тахал зэрэг эрүүл мэндийн онцгой нөхцөл байдлын үед олон хүн цугларах нь халдварыг тараах эрсдэлтэй гэж үзсэн тохиолдолд жагсаал цуглааныг хязгаарлаж эсвэл хориглож болно.
Олон нийтийн дэг журам	Олон нийтийн дэг журам, амар тайвныг алдагдуулж болзошгүй тохиолдолд эрх баригчид уг жагсаалыг хязгаарлах боломжтой. Жагсаал нь эмх замбараагүй байдал үүсгэх, халдах, эд хөрөнгө сүйтгэх зэрэг нөхцөл байдал үүсгэхээр бол уг арга хэмжээг хориглоно.
Үзэн ядалт, хүчирхийлэлд уриалах	Жагсаалын зорилго нь арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, хүйс, бэлгийн чиг баримжаа гэх мэт үндсэн дээр үзэн ядах, ялгаварлах үйл ажиллагаа явуулахад чиглэсэн бол эрх баригчид уг жагсаалыг хориглох эрхтэй. Шведийн хуульд үзэн ядалтын үг хэллэг болон хүчирхийлэлд уриалсан үйлдлийг хатуу хориглосон.
Зохион байгуулалтын журам зөрчсөн	Жагсаал зохион байгуулахын тулд тодорхой цаг хугацааны өмнө цагдаагийн байгууллагад мэдэгдэх шаардлагатай. Хэрэв зохион байгуулагчид уг журмыг зөрчвөл, эрх баригчид жагсаалыг хориглож эсвэл хязгаарлаж болно.

Хориглох байршил:

Нийтийн аюулгүй байдалд нөлөөлөх газруудад жагсаал цуглааныг хязгаарлах боломжтой. Жишээлбэл: Эмнэлэг, сургууль, цэргийн бааз зэрэг газрууд орно. Цэргийн зориулалттай газрууд, баазуудын ойролцоо жагсаал хийхийг нийтлэг хориглодог.

Хотын төвүүдийн тодорхой хэсэгт, зам тээврийн хөдөлгөөнд ихээхэн саад учруулах байршлуудад, тухайлбал гол зам, гүүр, нийтийн тээврийн зогсоол зэрэг газруудад хязгаарлалт тавьж болно.

Хугацаа:

Жагсаал цуглааныг тодорхой цагийн хязгаартай байлгах шаардлага тавьж болдог. Хэрэв жагсаал олон нийтийн амар тайван байдалд хэтэрхий удаан хугацаагаар сөрөг нөлөө үзүүлэхээр бол хугацааг хязгаарлаж болно. Орон нутгийн захиргаанаас тодорхой цагийн хязгаарыг зааж, шөнийн цагт эсвэл тодорхой өдрүүдэд жагсаал хийхийг хориглож болно.

Жагсаал цуглааныг хориглох шийдвэр гаргах эрх бүхий байгууллагууд:

“Олон нийтийн тайван байдал болон дэг журмыг хамгаалах тухай хууль”-д зааснаар жагсаал цуглааны хугацаа, байршил, оролцогчдыг хязгаарлах эсвэл хориглох эрх бүхий субъектүүд нь цагдаагийн байгууллага, орон нутгийн захиргаа, жагсаалын зохион байгуулагчид, шүүх зэрэг байгууллагууд гэж заасан байна. Эдгээр субъектүүд олон нийтийн аюулгүй байдал, дэг журмыг хангах зорилгоор хязгаарлалт хийх бөгөөд жагсаал, цуглаан хийх эрхийг Үндсэн хуулийн хүрээнд хамгаалах нь тэдний үүрэг юм.

Цагдаагийн байгууллага: Цагдаагийн газар бол жагсаал цуглааны үеийн аюулгүй байдал, олон нийтийн дэг журмыг хангах гол үүрэгтэй субъект юм. Шведийн цагдаагийн байгууллага жагсаал цуглааны үеэр эмх замбараагүй байдал гарах, олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах магадлалтай гэж үзвэл түүнийг хязгаарлах эсвэл хориглох шийдвэр гаргах эрхтэй. Зөвшөөрөлгүй эсвэл хууль бус жагсаалыг тараах арга хэмжээ авдаг. *(Олон нийтийн жагсаал цуглааны тухай хууль, 2 дугаар бүлэг 21, 25 дугаар зүйл)*

Орон нутгийн захиргаа: Шведэд захиргааны нэгжүүдэд тодорхой эрх мэдлүүд олгогдсон байдаг бөгөөд эдгээр эрх мэдлийн хүрээнд мужийн захиргаа тухайн бүс нутгийн аюулгүй байдал, нийгмийн амар тайван байдлыг хангахад чиглэсэн янз бүрийн хориг тавих шийдвэр гаргах боломжтой. *(Олон нийтийн жагсаал цуглааны тухай хууль, 2 дугаар бүлэг 15 дугаар зүйл)* Тухайлбал, Орон нутгийн захиргааны байгууллагууд нь тодорхой бүс нутагт олон нийтийн тайван байдлыг хангахын тулд жагсаал, цуглааны байршил болон хугацааг өөрчлөх буюу хориглох эрхтэй.

Шүүх: Хэрэв цагдаа болон орон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан жагсаалыг хориглох эсвэл хязгаарлах шийдвэрийг зохион байгуулагчид эсэргүүцэж байгаа бол шүүхэд хандаж болно. Шведийн шүүх жагсаал зохион байгуулах эрхтэй холбоотой аливаа маргааныг шийдвэрлэх эрхтэй бөгөөд шүүхээс гаргасан шийдвэр эцсийнх байдаг.

Жагсаал цуглааны үед хязгаарлалт тавих нөхцөл журам, тэдгээрийг тогтоох шалгуур

Зарим тохиолдолд жагсаалын зорилго нь Үндсэн хуультай зөрчилдөхгүй байвал тодорхой хязгаарлалттайгаар жагсаалыг зөвшөөрч болно. Тухайлбал, жагсаал хийх байршил, хугацаа, оролцогчдын тоог хязгаарлаж зохицуулалт хийх замаар олон нийтийн аюулгүй байдал болон дэг журмыг хангадаг байна.

Цагдаагийн байгууллага дараах нөхцөлд жагсаалын хугацаа, байршил, оролцогчдын тоонд хязгаарлалт тавих эсвэл бүрэн хориглох эрхтэй:

- *Хугацааны хязгаарлалт:* Жагсаал цуглааныг тодорхой цагийн хязгаартай байлгах шаардлага тавьж болдог. Орон нутгийн захиргаанаас тодорхой цагийн хязгаарыг зааж, шөнийн цагт эсвэл тодорхой өдрүүдэд жагсаал хийхийг хязгаарлаж болно.
- *Байршлын хязгаарлалт:* Хэрэв жагсаалын байршил нь эмзэг газар, төрийн байгууллагын ойролцоо, эсвэл олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулахуйц нөхцөлтэй гэж үзвэл жагсаал хийх байршлыг өөрчилж эсвэл тодорхой газар нутагт жагсаал зохион байгуулахыг хориглож болно. Тухайлбал замын хөдөлгөөн ихтэй эсвэл эмнэлэг, сургууль зэрэг газруудын ойролцоо жагсаал зохион байгуулахыг хориглох боломжтой.
- *Оролцогчдын хязгаарлалт:* Хэрэв оролцогчдын тоо хэт олон байснаар аюулгүй байдлын эрсдэл үүсэж болзошгүй гэж үзвэл оролцогчдын тоог хязгаарлах шийдвэр гаргаж болно. Мөн тодорхой бүлэг хүмүүсийн оролцоог аюулгүй байдал, дэг журамтай холбоотойгоор хязгаарлах боломжтой. Орон нутгийн захиргаа нь тухайн бүс нутгийн хэт олон хүн цуглах эсвэл тээврийн хэрэгсэлд саад учруулах нөхцөл байдлыг зохицуулахын тулд жагсаалын байршлыг өөр газар шилжүүлэх, тодорхой газарт хязгаарлалт тавих боломжтой.

Эрх бүхий байгууллагууд нь жагсаал цуглааны зохион байгуулалт болон аюулгүй байдлыг хангах үүрэгтэй учир, аль болох олон нийтийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулахгүйгээр зохицуулалт хийдэг. Хэрэв жагсаал нь хүчирхийлэл дэгдээх магадлалтай, эсвэл хэтэрхий олон хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй гэж цагдаа, захиргаанаас дүгнэвэл хязгаарлалт тавих үндэслэлтэй. (Epidemiology Act (Smittskyddslagen))

- *Бусад үйл ажиллагаатай зөрчилдөх:* Тухайн үед эсвэл байршилд өөр томоохон үйл ажиллагаа зохион байгуулагдаж байгаа бол нийтийн эмх замбараагүй байдлаас сэргийлж жагсаалыг өөр хугацаа, байршилд шилжүүлэх шаардлага тавьж болно.

2.2. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Холбооны Бүгд Найрамдах Герман улс нь (цаашид Герман улс гэх) жагсаал цуглаан хийх эрх, эрх чөлөөг хамгаалсан хуультай, улмаар уг хуулийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг нарийвчлан тодорхойлсон байдаг. Герман улс нь ард түмний жагсаал цуглаан хийх эрхийг хамгаалж ирсэн түүхэн уламжлалтай улс бөгөөд үүнийг Үндсэн хууль(Grundgesetz)-даа тусгасан байдаг.

Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх, эрх чөлөөний эрх зүйн зохицуулалт

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 8-р зүйлд (1) Бүх Германы иргэд урьдчилан мэдэгдэл, зөвшөөрөлгүйгээр тайван, зэвсэггүй цугларах эрхтэй, (2) Гудамж талбайд цугларах тохиолдолд энэ эрхийг хуулиар хязгаарлаж болно гэж заасан байдаг.

Энэхүү Үндсэн хуулийн заалтууд нь олон улсын хүний эрхийн стандартууд болон Герман улсын хууль, эрх зүйн тогтолцоотой нягт уялдаатай юм.

Мөн Герман улсад жагсаал, цуглаан хийхтэй холбоотой асуудлыг 1978 онд батлагдсан Жагсаал, цуглааны тухай хууль (Assembly act)-аар зохицуулдаг. Харин хуулийн дагуу нийтийн эзэмшлийн газар, муж, хотын гудамж талбайд жагсаал зохион байгуулж буй жагсагчид эсвэл оролцогчид хуульд заасан дараах эрх, үүргийг баримтлана. Тухайлбал,

Хүснэгт 4. Жагсаал, цуглаанд оролцогч, зохион байгуулагчийн эрх, үүрэг

Жагсаал цуглаанд оролцогчийн эрх	Хүн бүр олон нийтийн цуглаан, жагсаал хийх, ийм арга хэмжээнд оролцох эрхтэй. (Жагсаал, цуглааны тухай хуулийн 1-р зүйл)
Оролцогчийн үүрэг	- Цуглаанд оролцсон бүх хүмүүс хэв журам сахиулах талаар зохион байгуулагч эсвэл түүний томилсон туслах зохион байгуулагчдын өгсөн зааврыг дагаж мөрдөх үүрэгтэй. (Жагсаал, цуглааны тухай хуулийн 10-р зүйл)
Оролцох эрхгүй этгээд	- жагсаал, цуглаан хийх үндсэн эрхээ хязгаарлуулсан этгээд; - Холбооны Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн нам, намын хэсэг буюу түүнийг орлон гүйцэтгэгч байгууллагын зорилгыг сурталчлах үүднээс жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцохыг хүссэн хэн бүхэн; - Холбооны Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн нам, эсхүл;

	- Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хориглосон холбоо.
Зохион байгуулагчийн эрх	- Олон нийтийн цуглаан бүр удирдагчтай байх ёстой. - Цуглааныг холбооноос зохион байгуулж байгаа бол дарга нь удирдагч байна. - Зохион байгуулагч нь удирдлагыг өөр хүнд шилжүүлж болно. - Цуглааны удирдагч нь зохион байгуулагч юм. - Зохион байгуулагч нь хэв журмыг ноцтой зөрчсөн оролцогчдыг цуглаанд оролцуулахгүй байж болно.
Зохион байгуулагчийн үүрэг	- Зохион байгуулагч нь цуглааны явцыг тодорхойлдог. Зохион байгуулагч нь цуглааны үеийн хэв журмыг хангах ёстой. Тэрээр шаардлагатай бол цуглааныг түр зогсоох эсвэл өндөрлүүлж болно. Тэрээр түр зогсоосон цуглааныг хэзээ үргэлжлүүлэхийг тодорхойлно. (Жагсаал цуглааны тухай хуулийн 2-р зүйл)

Цахим жагсаал, цуглаан зохион байгуулах эрх зүйн зохицуулалт

Герман улсад "цахим жагсаалын тухай хууль" байдаггүй ч иргэд цахимаар эвлэлдэн нэгдэж үзэл бодлоо илэрхийлэх нь тус улсын өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн зохицуулалтад хамаардаг байна. ХБНГУ-ын Үндсэн хуульд заасан жагсаал, цуглаан хийх, үг хэлэх эрх, эрх чөлөө нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах, өргөдөл гаргах, виртуал цуглаан зэрэг цахим жагсаал, цуглаануудад хамаарна. Гэхдээ эдгээр эрхийг хувийн нууцыг хамгаалах, үзэн ядсан үг хэллэгээс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ашиглалтыг зохицуулах зэрэг бусад хууль тогтоомжтой нийцүүлэн эдэлнэ. Цахим жагсаал, цуглааныг Герман улсын хууль, эрх зүйд хэрхэн нийцүүлэхтэй холбоотой гол үндэслэлүүдийг дурдвал:

1. *Цахимаар үзэл бодлоо илэрхийлэх, цуглаан хийх эрх чөлөө:*

   Герман улсын хууль тогтоомж нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, хувь хүмүүст олон нийтийн сүлжээ, блог, вэбсайтаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгоно.

   Цахим өргөдөл, гомдол хүлээн авахыг уламжлалт эсэргүүцлийн эрхтэй нийцсэн цуглааны нэг хэлбэр гэж үздэг.

2. *Үзэн ядсан үг хэллэг, хувийн нууцыг хамгаалах тухай журам:*

   Герман улс үзэн ядсан үг хэллэг, гүтгэлэг, хүчирхийллийг өөгшүүлэхийн эсрэг хатуу хуультай бөгөөд энэ нь цахим жагсаал, цуглаанд хамааралтай байна.

   Сүлжээний хэрэгжилтийн тухай хууль (NetzDG)-д зааснаар олон нийтийн мэдээллийн хэрэгслийн платформууд нь зохисгүй үг хэллэг гэх зэрэг хууль бус контентыг мэдэгдсэнээс хойш 24 цагийн дотор устгах үүрэгтэй.

3. *Мэдээллийн хамгаалалт:*

   Цахим жагсаал зохион байгуулагчид нь “Ерөнхий өгөгдөл мэдээллийг хамгаалах тухай зохицуулалт (General Data Protection Regulation)/GDPR/-ийг дагаж мөрдөх ёстой. Үүнд,

оролцогчдын хувийн мэдээллийг хариуцлагатайгаар цуглуулах, боловсруулах, хувийн нууцын эрхийг зөрчихгүй байх зэрэг орж байна.

Жагсаал цуглааны тухай хуульд онлайн буюу цахим жагсаалыг тодорхой тусгаагүй ч Герман дахь цахим орон зайд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх, хувийн мэдээллийг хамгаалахад чиглэсэн тогтолцоотой байна.

Жагсаал, цуглааны үе шат бүрт хамгаалалтыг хэрхэн хийх

Герман улсад жагсаал, цуглааныг бүх үе шатанд нь хуулийн дагуу аюулгүй зохион байгуулахын тулд зохион байгуулагчид болон оролцогчид тус улсын хууль эрх зүйн орчин, түүнд заасан эрхийнхээ талаар мэдлэгтэй байх шаардлагатай байдаг. Жагсаал цуглааны үе шатуудад:

1. *Төлөвлөлтийн үе шат*

   Жагсаал цуглааныг бүртгэх: Олон нийтийн эзэмшлийн гудамж, талбайд жагсаал цуглаан зохион байгуулахдаа хуульд заасны дагуу арга хэмжээг олон нийтэд зарлахаас өмнө төрийн захиргааны холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой бөгөөд энэ нь уг жагсаалыг хууль ёсны дагуу хүлээн зөвшөөрч, цагдаагийн ажилтнууд хэв журам сахиулан ажиллах үндэслэл болно.

2. *Жагсаал, цуглааны үед*

   Хууль, журмыг дагаж мөрдөх: Зэвсэг хэрэглэхээс зайлсхийх, зөвхөн эрүүл мэндийн зайлшгүй шалтгаанаар маск зүүх гэх зэрэг аюулгүй байдлын үүднээс дагаж мөрдөх дүрэм журмууд бий. Энэ нь цагдаа хүчний байгууллагын зүгээс олон нийтийн аюулгүй байдлыг сахин хамгаалах үндэслэлээр тухайн жагсаал, цуглааныг тараах шалтаг, шалтгаан үүсгэхээс урьдчилан сэргийлж буй хэрэг юм.

   Тайван жагсаал: Ямарваа хүчирхийллийн шинж чанартай үйл үйлдэл ажиглагдсан даруйд төр захиргааны байгууллагын зүгээс тухайн жагсаал цуглааныг нэн даруй тарааж болзошгүй тул тайван жагсах бүх талын нөхцөлийг ханган бүрдүүлнэ.

   Үүнд, жагсаал, цуглааныг төлөөлөн удирдаж буй хүмүүс нь хууль сахиулах байгууллагатай харилцаж, хамтран ажиллах харилцааг хариуцна.

   Үйл явдлыг баримтжуулах: Цагдаа хүчний байгууллагын үйл ажиллагаа, эрх зөрчигдсөнтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд нотлох баримт бүрдүүлэхийн тулд камер гэх зэрэг зохих тоног төхөөрөмжийг ашиглан жагсаал цуглааны үйл ажиллагааг бичиж баримтжуулна.

3. *Жагсаал цуглааны дараа*

   Хууль эрх зүйн дэмжлэг: Оролцогчдыг саатуулсан эсвэл жагсаалыг зогсоосон тохиолдолд хүний эрхийн байгууллагуудаас хуулийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг. Эмнести Интернэшнл болон орон нутгийн хууль зүйн туслалцаа үзүүлэх бүлгүүд хуулийн асуудлыг шийдвэрлэхэд нь тусалдаг байна.

Гомдол гаргах: Жагсаал, цуглаан хийх эрхийг зөрчсөн (жишээ нь, цагдаагийн зүгээс хүч, хэрэгсэлийг зохисгүй хэрэглэсэн гэх мэт) гэж үзвэл хяналтын байгууллага, эсхүл хүний эрхийн байгууллагад гомдол гарган шийдвэрлүүлэх боломжтой байна.

Жагсаал, цуглааныг хориглох (хугацаа, байршил, оролцохыг хориглох субъект)

Жагсаал, цуглааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар олон нийтийн жагсаал, цуглааныг задгай талбайд зохион байгуулах гэж байгаа бол зохион байгуулагч нь жагсаал, цуглааныг зарлахаас багадаа 48 цагийн өмнө эрх бүхий байгууллагад мэдэгдэх ёстой байдаг.

Харин дотор цугларах үед бүртгэлийн үүрэг хариуцлага хүлээхгүй. Энэ нь зохих хүрээнд хаалттай, гудамж талбайд зохион байгуулагдаж буй жагсаал, цуглаантай харьцуулахад оролцогчдын тоо хязгаартай байдагтай холбоотой. Тэгвэл гудамж, талбайд зохион байгуулж буй жагсаал, цуглаан нь оролцогчдын тоо хязгааргүй, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам гэх зэргээр илүү олон хууль журмын асуудлуудтай холбоотой байна. Мөн тодорхой нөхцөлд аяндаа бий болсон жагсаалын мэдэгдлийг зөвшөөрдөг ч олон нийтийн аюулгүй байдалд эрсдэлтэй тохиолдолд төр захиргааны холбогдох байгууллага нь зөвшөөрөл өгөхөөс татгалзаж болдог байна.

Мөн Жагсаал, цуглааны тухай хуулийн 15.2.1-т Үндсэрхэг үзэлт нийгмийн хүчирхийлэл, дур зоргоороо дэглэмийн үеийн хүнлэг бус харгислалын хохирогчдод зориулсан түүхэн онцлогтой, дурсгалт газарт жагсаал, цуглаан хийхийг хориглосон байдаг байна.

Үүнд, Европт хөнөөгдсөн еврейчүүдийн дурсгалд зориулсан Берлин дэх газар зэрэг хамаарах бөгөөд бусад үүнтэй адил газар, тэдгээрийн хамгаалалтын бүсийг муж улсын хуулиар тогтоодог байна.

Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Холбооны Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн нам, түүний салбар байгууллага, тухайн намыг орлох байгууллагын зорилгыг сурталчлахыг хүссэн хэн бүхнийг, мөн Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хориглосон холбоог үүнтэй адил хэрэг зорилгоор жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцохыг хориглодог байна.

Жагсаал, цуглааны үед хязгаарлалт тавих нөхцөл, журам

Герман улсад олон нийтийн эзэмшлийн газар, гудамж талбайд жагсаал, цуглаан хийх эрхийг Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хязгаарлах боломжтой.

Тус улсын хууль тогтоомжид цагдаагийн байгууллагын зүгээс жагсаал, цуглааны үеэр галт зэвсэг хэрэглэж болох эсэх талаар тусгайлсан зохицуулалт байхгүй. Гэхдээ нийтийн эзэмшлийн газар, тухайлбал, хотын гудамж, талбайд жагсаал зохион байгуулж буй болон жагсаалд оролцогчдод бусдад аюул учруулж болзошгүй зэвсэг, эд зүйлсийг биедээ авч явахыг хориглодог. Мөн жагсагчид нүүрээ нуусан маск зэрэг халхавч хэрэглэх, дүрэмт хувцас өмсөх зэргийг хориглодог байна.

Үндсэн хуулийн 83, 84 дүгээр зүйлд заасны дагуу холбооны муж бүр Ассамблейтэй бөгөөд тэдгээр нь тус тусын мужийн түвшний хуулийг тогтооно. Үүнд, жагсаал, цуглааны зөвшөөрөл олгох, аюулгүй байдлыг хангах ажлыг хариуцах төрийн захиргааны байгууллагыг тогтоох

асуудал ч хамаарна. Ерөнхийдөө аливаа жагсаал, цуглааныг зохион байгуулагч нь холбогдох захиргаанд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэл өгсний дараа тусгайлан зөвшөөрөл авах шаардлагагүй тул эрх бүхий байгууллагаас ямар нэгэн хариу хүлээх албагүй. Гэхдээ эрх барих байгууллагын зүгээс тухайн жагсаал, цуглаантай холбоотойгоор зарим нэг аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах шаардлагатай гэж үзвэл зохих хязгаарлалтыг хийх эрхтэй байдаг байна.

2.3. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС[19]

БНСУ нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966)-д нэгдсэн улс бөгөөд иргэдийнхээ жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиараа баталгаажуулсан байдаг.

Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх, эрх чөлөөний эрх зүйн зохицуулалт

1948 оны БНСУ-ын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд “бүх иргэд цуглах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг эдэлнэ” гэж заажээ.

Ийнхүү иргэдийнхээ жагсаал, цуглаан хийх эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиараа баталгаажуулснаас гадна уг харилцааг “Жагсаал, цуглааны тухай” бие даасан хуулиар зохицуулж байна.

Жагсаал, цуглааны тухай хууль нь иргэдийн хууль ёсоор жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг баталгаажуулж, иргэдийг хууль бус жагсаал, цуглаанаас хамгаалах зорилготой ажээ.

Тус хуулиар жагсаал, цуглааны тодорхойлолт, зохион байгуулагч, оролцогчдын эрх үүрэг, хориглох үйл ажиллагаа, жагсаал, цуглаан зохион байгуулах үйл явц, хориглох, хязгаарлах нөхцөл, цагдаагийн байгууллагын хамгаалах эрх хэмжээ болон шаардлага, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулсан байна.

Хуульд тодорхойлсноор “**Гадна цуглаан**” гэж дээвэр, бүрээсгүй, эсвэл дөрвөн тал нь хаагдаагүй задгай талбайд хийж буй цуглааныг; “**Жагсаал**” гэж зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн зэрэг олон нийтийн чөлөөтэй зорчих боломжтой олон нийтийн эзэмшлийн газруудад нэгдмэл зорилгын дагуу жагсаж, эсвэл өөрсдийн хүсэл зоригоор олон тооны хүмүүсийн санал бодолд нөлөөлөх зорилгоор жагсаж буй хэсэг бүлэг хүмүүсийн үйлдлийг хэлнэ.

Нийтийн эзэмшлийн гудамж талбайд жагсаал, цуглаан хийхийг хүссэн аливаа хүн уг жагсаал, цуглаан хийхээс 48-72 цагийн өмнө гол зорилго, зохион байгуулах огноо болон үргэлжлэх хугацаа, газар, зохион байгуулагч, оролцохоор төлөвлөж буй байгууллагууд, оролцогчдын тоог хэчнээн гэж тооцоолж буй, жагсаал цуглааны арга хэлбэр, маршрут (тус хуулийн 6 дугаар зүйл) зэргийг багтаасан мэдээлэл бүхий мэдэгдлийг холбогдох цагдаагийн газрын даргад ирүүлэх үүрэгтэй.

[19] The International Human Rights Framework on the Right of Peaceful Assembly, South Korea, https://www.rightofassembly.info/country/south-korea

Цахим жагсаал, цуглаан зохион байгуулах эрх зүйн зохицуулалт

БНСУ-д цахим жагсаал, цуглааныг зохицуулсан тусгай хуулийн зохицуулалт одоогоор байхгүй байна. Хэдий тийм боловч цахимаар эвлэлдэн нэгдэж, үзэл бодлоо илэрхийлэхэд бүдүүлэг үг яриа хэрэглэхгүй байх, хувь хүний нууцыг хамгаалах, бусдыг гүтгэн доромжлохгүй байх гэхчилэн хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, хувь хүний нууцын тухай хууль болон цахим орчны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжуудаар зохицуулж байна.

Цахим орчинд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан зохион байгуулах зэрэг нь хүний үндсэн эрх болох үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөнд хамаарах бөгөөд биечлэн жагсаал, цуглаан хийх зохицуулалтад мөн хамаарна. Тухайлбал, БНСУ-ын Үндсэн хуульд "…. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдын нэр төр, эрхийг зөрчиж, нийтийн ёс суртахуун, нийгмийн ёс зүйг гутааж болохгүй. Хэрэв бусдын нэр төр, эрхийг зөрчсөн тохиолдолд түүнээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болно" гэж заажээ.

Жагсаал, цуглааны үе шат бүрт хамгаалалтыг хэрхэн хийх

Жагсаал, цуглааны тухай хуулийн 3-р зүйлд зааснаар аливаа тайван жагсаал, цуглаанд хэн ч саад болж, дэг журмыг нь зөрчиж болохгүй. Мөн жагсаал, цуглаан зохицуулагчийг хуульд заасан үүргээ биелүүлэх явцад хүчирхийлэл, заналхийлэл, бусад аргаар саад учруулж болохгүй.

Харин тайван жагсаал, цуглаанд саад учруулж болзошгүй гэсэн үндэслэл байгаа тохиолдолд жагсаал, цуглааныг зохион байгуулагч ийм эрсдэлийн талаар цагдаагийн эрх бүхий байгууллагад мэдэгдэж, түүнийг хамгаалах хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд цагдаагийн эрх бүхий байгууллагын дарга хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамгаалалт авах хүсэлтээс татгалзаж болохгүй гэж заасан байна.

Жагсаал, цуглааны үед оролцогчдын болон бусад иргэдийн аюулгүй байдлыг хангахад зохион байгуулагчид, оролцогчдод ихээхэн хариуцлага ногдуулж, хэрвээ зохион байгуулагч цуглаан, жагсаалыг эмх цэгцтэй явуулж, дэг журмыг сахиулж чадаагүй тохиолдолд тэр жагсаал, цуглааныг тараахаар (16.3-т) зохицуулсан байна.

Цуглаан, жагсаал зохион байгуулагчид хориглосон үйлдлийг дараах байдлаар хуульд заажээ:

1.Бусдын амь нас, бие махбодын аюулгүй байдалд аюул, хохирол учруулж болзошгүй галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, хутга мэс, чулуу гэх мэт бусад хэрэгслийг авч явах, ашиглах, эсхүл бусдад авч явах, ашиглахыг шаардах;

2.Хүчирхийлэл, заналхийлэл, устгах, галдан шатаах зэргээр эмх журам зөрчих;

3.Жагсаал цуглааны үндсэн зорилго, огноо, цаг, газар, арга хэлбэрийг илт зөрчсөн үйлдэл гаргах.

Энэ хуулийн 17 дугаар зүйлд заасанчлан зохицуулагчид нь уг жагсаал, цуглааныг зохион байгуулагчийн зааврын дагуу жагсаал, цуглааны дэг журмыг сахиулах үүрэгтэй. Зохицуулагчдын үүрэг их чухал тул Цагдаагийн эрх бүхий байгууллагын дарга жагсаал,

цуглаан зохион байгуулагчтай зөвшилцсөний үндсэн дээр зохицуулагчдын тоог хамгийн оновчтой хүний тоонд тохируулж болно (17.4).

Хуулийн 18 дугаар зүйлд оролцогчдын анхаарах асуудлыг заахдаа жагсаал, цуглаанд оролцож буй аливаа хүн дэг журмыг сахиулах талаар зохион байгуулагч болон зохицуулагчдын өгсөн зааврыг дагаж мөрдөх ёстой бөгөөд зохион байгуулагчид хориглосон аливаа үйлдлийг хийх ёсгүй байна.

Жагсаал цуглааны үеэр цагдаагийн ажилтны нэвтрэх эрхийн тухайд тус хуулийн 19 дүгээр зүйлд:

(1) Цуглаан, жагсаал зохион байгуулагчид мэдэгдсэний дараа дүрэмт хувцастай цагдаагийн алба хаагч жагсаал, цуглаан хийх газар руу орох боломжтой: Хэрэв дотор цуглаан зохион байгуулж байгаа газарт нэвтрэх бол зөвхөн үүргээ биелүүлэх зайлшгүй шаардлагатай тохиолдлоор хязгаарлагдана.

(2) Жагсаал, цуглаан зохион байгуулагч, зохицуулагч, эсхүл уг жагсаал, цуглаан хийх газрын хамгаалагч нь дэг журам сахиулах үүргээ биелүүлэхэд цагдаагийн алба хаагчидтай хамтран ажиллана гэхчлэн заажээ.

Тэгэхээр БНСУ-ын хуулиар жагсаал, цуглааны бүх үе шатанд аюулгүй байдлыг хангах тухайд зохион байгуулагч, зохицуулагч, оролцогчдод өндөр үүрэг хариуцлага ногдуулсан зохицуулалттай байна.

Жагсаал, цуглааны зөвлөлдөх хороо:

Хуулийн 21-р зүйлд зааснаар Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг олон нийтийн амгалан тайван байдал, дэг журмыг сахиулах хэрэгцээтэй тэнцвэржүүлэхийн тулд шат шатны цагдаагийн байгууллага бүрд жагсаал, цуглааны талаар зөвлөлдөх хороо байгуулж болно. Хороо нь цагдаагийн байгууллагын даргад дараах асуудлаар зөвлөгөө өгнө.

1. Жагсаал, цуглаан хийхийг хориглох, хязгаарлах тухай мэдэгдэл;
2. Гомдлын талаар гаргасан нэхэмжлэл;
3. Жагсаал, цуглаан хийсэн хэргийг шалгах;
4. Жагсаал, цуглаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх.

Жагсаал, цуглааныг хориглох (хугацаа, байршил, оролцохыг хориглох субъект)

1948 оны Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хуулийн 37-р зүйлд цугларах эрхийг хязгаарлах үндэслэлийг “үндэсний аюулгүй байдал, хэв журмыг сахиулах, нийтийн сайн сайхны төлөө шаардлагатай үед хязгаарлаж болно…, хязгаарлалт нь эрх чөлөө, эрхийн аливаа чухал талыг зөрчиж болохгүй” гэж заасан байна.

Мөн Жагсаал, цуглааны тухай хуулийн 4-р зүйлд, Жагсаал цуглаан зохион байгуулагч, зохицуулагч нь тодорхой хувь хүн, эсхүл байгууллагыг жагсаал, цуглаанд оролцуулахгүй байж болно: Хэрэв хэвлэл, мэдээллийн байгууллагын сурвалжлагчийг чөлөөтэй нэвтрэхийг баталгаажуулсан тохиолдолд тэдгээр нь үнэмлэхээ үзүүлж, сурвалжлагч гэдгээ илтгэх тууз зүүсэн байхыг шаарддаг.

Жагсаал, цуглаан хийхийг хориглох:

Дараах дэд зүйлд хамаарах аливаа жагсаал, цуглааныг хэн ч хийж болохгүй.

1.Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр татан буугдсан улс төрийн намын зорилгод хүрэхийг оролдсон жагсаал, цуглаан; болон

2. Хамтын хүчирхийлэл, заналхийлэл, устгах, галдан шатаах зэргээр өдөөн хатгаж, нийтийн амгалан тайван байдал, дэг журамд шууд заналхийлсэн нь тодорхой болсон цуглаан, жагсаал.

Энэ мэт хориглосон жагсаал, цуглааны талаар суртал ухуулгын кампанит ажил явуулахгүй, эсхүл ийм цуглаан хийх, жагсаал зохион байгуулахад хүмүүсийг турхирыг хориглодог.

Жагсаал, цуглаан хийхийг хориглох, хязгаарлах тухай мэдэгдэл:

Хуулийн 8-р зүйлд зааснаар Жагсаал, цуглаан зохион байгуулах тухай мэдээллийг хүлээн авсан цагдаагийн эрх бүхий байгууллагын дарга, хэрэв түүнд мэдэгдсэн гадаа цуглаан, жагсаал нь дараах тохиолдлын аль нэгэнд хамаарах бол мэдээллийг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор цуглаан, жагсаал хийхийг хориглох тухай зохион байгуулагчид мэдэгдэнэ:

- хүчирхийлэл, заналхийлэл, устгах, галдан шатаах гэх мэтээр цуглаан, жагсаал нь нийтийн амгалан тайван байдал, дэг журамд шууд заналхийлсэн тохиолдолд уг жагсаал, цуглааны үлдсэн хугацааны хувьд тайланг хүлээн авснаас хойш 48 цаг өнгөрсний дараа ч гэсэн түүнийг үргэлжлүүлэхийг хориглосон тухай зохион байгуулагчид мэдэгдэж болно.
- Нэг газар нэгэн зэрэг, ижил эсвэл зөрчилдсөн зорилготой жагсаал, цуглаан зохион байгуулах 2 болон түүнээс дээш мэдэгдэл ирүүлсэн бол сүүлд хүлээн авсан мэдэгдлийн жагсаал, цуглаан хийхийг хориглоно.

Мэдэгдэлд заасан газарт оршин суугч эсвэл тухайн байгууламжийн удирдлага нь жагсаал, цуглаан хийхийг хориглох, хязгаарлахыг хүсэж, газар, байгууламжийг хамгаалалтад авах тухай хүсэлт гарган мэдэгдэж болно. Ийм тохиолдолд жагсаал, цуглаан хийхийг хориглосон мэдэгдэлд өөрчлөлт оруулна:

1. Мэдэгдэлд заасан газар (цаашид "мэдээлсэн газар" гэх) нь суурьшлын бүс буюу түүнтэй адилтгах газарт жагсаал, цуглаан хийх нь хувийн өмч, байгууламж, оршин суугчдын хувийн орон зайд ноцтой халдах, хохирол учруулж болзошгүй тохиолдолд;

2. Мэдээлсэн газар нь сургуулийн эргэн тойронд байрлах газар тул жагсаал, цуглаан нь суралцах эрхийг ноцтой зөрчих магадлалтай гэж үзвэл;

3. Мэдээлсэн газар нь цэргийн байгууламжийн ойролцоо байх, жагсаал, цуглаан хийх нь цэргийн байгууламж, цэргийн ажиллагаа явуулахад ноцтой хохирол учруулж болзошгүй тохиолдолд.

Жагсаал, цуглаан хийхийг хориглосон, хязгаарласан тухай мэдэгдлийг хориглох, хязгаарлах үндэслэлийг тодорхойлон бичгээр үйлдэж, цуглаан, жагсаал зохион байгуулагч, эсхүл харилцаа холбоо хариуцсан этгээдэд илгээнэ.

Гадаа жагсаал, цуглаан хийхийг хориглох:

Хуулийн 10-р зүйлд зааснаар нар мандахаас өмнө, жаргасны дараа хэн ч гадаа жагсаал, цуглаан хийж болохгүй: Цагдаагийн эрх бүхий байгууллагын дарга нар мандахаас өмнө, бүр

жаргасны дараа зохион байгуулагч нь уг цуглааныг зохион байгуулах талаар урьдчилан мэдээлсэн, тухайн арга хэмжээний мөн чанар нь тухайн цагуудад зохион байгуулах зайлшгүй бол дэг журам сахиулахаар гадаа цуглаан хийхийг зөвшөөрч болно.

Мөн гадаа цуглаан, жагсаал хийхийг хориглосон газруудыг тус хуулийн 11-р зүйлд нарийвчлан заасан байдаг. Үүнд:

1. Үндэсний Их Хурлын байр, бүх шатны шүүх, Үндсэн хуулийн цэц;
2. Ерөнхийлөгчийн өргөө болон Улсын Их Хурлын дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн цэцийн даргын албан ёсны өргөө;
3. Ерөнхий сайдын албан ёсны оршин суух газар; болон
4. Солонгос дахь дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнүүдийн оршин суух газар зэргийн барилга байшингаас 100 метрийн ойр орчимд жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглодог.

Жагсаал, цуглааны үед хязгаарлалт тавих нөхцөл, журам

Жагсаал, цуглааны тухай хуулийн дагуу Цагдаагийн эрх бүхий байгууллагын дарга Ерөнхийлөгчийн зарлигаар томоохон хотын төв замд хөдөлгөөний жигд урсгалыг хангахаар жагсаал, цуглаан хийхийг хориглох, эсвэл шаардлагатай гэж үзвэл замын хөдөлгөөний дэг журмыг сахиулах нөхцөлийг зааж, хязгаарлаж болно.

Чанга яригч ашиглахыг хязгаарлах:

Аливаа жагсаал, цуглаан зохион байгуулагчид Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон дуу чимээний түвшнээс хэтэрсэн чанга яригч, бөмбөр, жижиг эсвэл том гонг гэх мэт төхөөрөмж, хэрэгслийг ашиглан бусдад ноцтой хохирол учруулах аливаа чимээ шуугиан гаргахыг хориглоно.

Мөн цуглаан, жагсаал зохион байгуулагч нь дээрх дуу чимээний түвшнээс хэтэрсэн дуу чимээ гаргаж бусдад хор хөнөөл учруулж байгаа тохиолдолд цагдаагийн эрх бүхий байгууллагын дарга зохион байгуулагчид дуу чимээний түвшинг бууруулах, эсвэл чанга яригч гэх мэтийн хэрэглээг түр зогсоох эсвэл чанга яригчийг түр болиулах гэх мэт шаардлагатай арга хэмжээ авна.

Жагсаал цуглааныг албадан тараах:

Дараах тохиолдолд жагсаал, цуглааныг цагдаагийн эрх бүхий байгууллагаас зохих хугацаанд сайн дураараа тарахыг шаардаж болох бөгөөд хэрэв шаардлагыг биелүүлээгүй бол албадан тараана:

- хориглосон жагсаал, цуглаан;
- хориглосон газар зохион байгуулж буй жагсаал, цуглаан;
- хориглосон жагсаал, цуглааныг турхирсан;
- хориглосон мэдэгдлийг зөрчсөн жагсаал, цуглаан;
- хөдөлгөөний жигд урсгал гэх мэт эмх журам сахиулахад илт заналхийлсэн аливаа жагсаал, цуглаан;
- үймээн самуун, хориглосон нөхцөл байдлууд үүссэн тохиолдолд;
- хууль журмыг зөрчсөн аливаа үйл, үйлдэл гаргасан тохиолдолд.

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага:

Тайван жагсаал, цуглаан зохион байгуулах явцад саад учруулсан, хүчирхийлэл, заналхийлэл, бусад арга хэлбэрээр дэг журмыг зөрчин саад учруулсан аливаа этгээдийг гурваас илүүгүй жил хорих, эсвэл гурван сая воноос илүүгүй торгууль ногдуулна: Зэвсэгт хүчний гишүүн, улсын яллагч, цагдаагийн ажилтан бол таваас дээш жил хорих ял шийтгэнэ.

Хориглосон мэдэгдэл гаргасан жагсаал, цуглаан зохион байгуулсан этгээдийг 2-оос дээшгүй хугацаагаар хорих эсхүл хоёр сая воноос хэтрэхгүйгээр торгох ял шийтгэнэ.

Хориглосон жагсаал, цуглааныг сурталчилсан, түүнийг зохион байгуулахад бусдыг турхирсан аливаа этгээдийг нэг жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсвэл нэг сая воноос илүүгүй торгууль ногдуулна.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр татан буугдсан улс төрийн намын зорилгод хүрэхийг оролдсон жагсаал, цуглаанд мэдсээр байж оролцсон этгээдийг зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, таван зуун мянга воноос дээшгүй торгох шийтгэл хүлээлгэнэ.

Хориглосон жагсаал, цуглаан зохион байгуулагчийг нэг жилээс дээшгүй хугацаагаар хорих, эсхүл нэг сая воноос дээшгүй төгрөгөөр торгох; Зохицуулагчийг зургаан сараас дээшгүй хугацаагаар баривчлах, 500 000 воноос хэтрэхгүй торгох, хорих, бага хэмжээний торгох; болон мэдээгээр цуглаан, жагсаалд оролцсон хүнийг 500 мянган воноос дээшгүй мөнгөн дүнгээр торгох, баривчлах, хөнгөн торгох ял шийтгэнэ.

Мөн жагсаал, цуглаан зохион байгуулагч болон зохицуулагчаас тухайн жагсаал, цуглаанд оролцохыг хассан этгээд оролцсон тохиолдолд, хуурамчаар мэдээлэл хийж, жагсаал цуглаан хийсэн этгээд, цагдаагийн албан хаагчийн анхааруулгыг үл харгалзан шугамыг давсан, шаардлага биелүүлээгүй зэрэг этгээдийг зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, 500 мянган воноос дээшгүй торгох, баривчлах зэрэг ял шийтгэл ногдуулахаар тус тус зохицуулсан байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- https://ikon.mn/n/z1y
- Жагсаал, цуглааны үеэр хэв журам сахиулахад баримтлах хүний эрхийн гарын авлага, https://www.osce.org/files/f/documents/b/7/524223.pdf
- http://www.e-khutuch.mn/guide/show/51/465
- Ардчилсан засаглал ба тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай дараах Хамтарсан Тунхаглал, https://www.gic.mn/post/r/1651
- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн төсөлд зориулсан харьцуулсан судалгаа, 2022 он, https://sudalgaa.gov.mn/LELLtP

Швед

- https://www.riksdagen.se/ Шведийн үндсэн хууль, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Олон нийтийн тайван байдал болон дэг журмыг хамгаалах тухай хууль, Дотоодын мэдээллийн хамгаалалтын хууль[1] Цагдаагийн тухай хууль, Эрүүгийн хууль.
- ЕАБХАБ/АХЭБ болон Венецийн Комисс, Тайван хуран цуглах эрхийн талаарх удирдамж, (2010),
- https://pts.se/ Цахим харилцааны тухай хууль
- https://www.notisum.se/ Цагдаагийн тухай хууль
- The Swedish Police Authority Strategy for Crime Prevention Work, 2022 он.
- Олон нийтийн цуглаан ба Шведийн аюулгүй байдал, Засгийн газрын судалгаа, 2024 он
- https://bra.se/ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний зөвлөлийн албан ёсны цахим хуудас.
- https://www.lagboken.se/ Шведийн Дотоодын мэдээллийн хамгаалалтын хууль, (Dataskyddsförordningen)
- Харьцуулсан эрх зүй, Амарсанаа.Ж нар, 2013 он
- “Зөвлөлдөж шийдье” Зөвлөлдөх санал асуулга, УИХ, 2023 он
- Олон нийтийн жагсаал цуглаан ба Шведийн аюулгүй байдал, 2024

ХБНГУ

- https://www.gesetze-im-internet.de/versammlg/BJNR006840953.html
- https://www.gesetze-im-internet.de/versammlg/
- https://gdpr-info.eu/
- https://www.dw.com/en/freedom-of-assembly-in-germany-protected-but-regulated/a-39630488
- https://www.gesetze-im-internet.de/gg/

БНСУ

- The International Human Rights Framework on the Right of Peaceful Assembly, South Korea, https:// www.rightofassembly.info/country/south-korea
- Korea (Republic of)'s Constitution of 1948 with Amendments through 1987, https://www.constituteproject.org/constitution/Republic_of_Korea_1987.pdf?lang=en
- Constitution of the Republic of Korea (No. 10, Oct. 29, 1987), https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1